

ОХУ-ын ДХБ-д нэгдэн орох үйл явц

Монгол-Оросын худалдаан дахь тарифын бус саад тотгор, стандартуудын талаарх судалгааны дүн шинжилгээ

Төслийн дугаар: № G/21/04

*Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГТХАН)-ийн
Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төсөлд зориулан*

Эдийн засаг, эрх зүйн зөвлөгөө (ЭЗЭЗ) ХХК гүйцэтгэв.

Улаанбаатар хот, Монгол Улс

2005 оны 12-р сар

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	2
ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	3
ХУРААНГУЙ	4
1. Судалгааны зорилт	5
2. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх явц	5
3. Судлагдсан тарифын бус саад тотгор, арга хэмжээний жагсаалт	6
ОРШИЛ	7
1. ДХБ ба ОХУ	7
2. Монгол-Оросын худалдаа	8
ОХУ-ЫН ДХБ-Д НЭГДЭН ОРОХ ҮЙЛ ЯВЦ	10
1. Давуу болон сул тал	11
2. Эерэг тал	11
3. Сөрөг тал	11
ОЛОН УЛСЫН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ ОХУ-ЫН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ	12
1. Олон улсын худалдааны тарифын зохицуулалт	12
2. ОХУ-ын гаалийн болон тарифын бодлогын хөгжил	13
3. ОХУ-ыг ДХБ-д элсэхтэй холбогдсон тарифын бодлого	14
4. Олон улсын худалдааны тарифын бус зохицуулалт	14
5. Олон улсын худалдаанд харилцан тохиролцсон тарифын бус зохицуулалтыг хэрэглэх явц дахь олон улсын эрх зүйн тогтолцоо	15
6. ОХУ ба ДХБ: Хөдөө аж ахуйн байдал	15
7. Эрүүл ахуйн арга хэмжээг ашиглах талаарх гэрээ	16
8. ОХУ-ын үндэсний таатай нөхцөл үзүүлэх тогтолцоо	16
МОНГОЛ-ОХУ-ЫН ХУДАЛДААНД УЧИРЧ БУЙ ТАРИФЫН БУС СААД ТОТГОРУУД	18
1. Монгол-Оросын худалдааны өнөөгийн байдал	18
2. ОХУ-ын ДХБ-д элсэн орох ажлын хүрээнд хийгдэж буй ажлууд	19
МОНГОЛЫН ЭКСПОРТЛОГЧ КОМПАНИУДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД	21
1. Махны экспортод тогтоосон квот	22
2. Махны экспортод тогтоосон нутаг дэвсгэрийн хязгаарлалт	23
3. Мал эмнэлгийн болон эрүүл ахуйн хяналт	23
4. Стандартын шаардлага	24
МОНГОЛЫН ИМПОРТЛОГЧ КОМПАНИУДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД	25
АЛТАНБУЛАГ, СЭЛЭНГИЙН ГАНЗАГЫН НАЙМААЧДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД	27
ТЭЭВЭРЛЭЛТ, ХУДАЛДААНД УЧИРЧ БУЙ СААД ТОТГОРУУД	29
МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДАА: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	30
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	32
ХАВСРАЛТ 1. Дэлхийн Худалдааны Байгууллага	35
ХАВСРАЛТ 2. Ажлын хэсгийн үйл ажиллагаа болон Сайд нарын бага хурлын тэмдэглэл	36
ХАВСРАЛТ 3. Сэдэвт орсон нэр томьёо, тодорхойлолт	38
ХАВСРАЛТ 4. Мал эмнэлэг болон эрүүл ахуйн шаардлагууд	40

МУ-ОХУ-ын худалдаан дахь тарифын бус саад тотгор, стандартын талаарх судалгаа-дүгнэлтийг гүйцэтгэсэн:

ЭЗЭЗ ХХК - Эдийн засаг Эрх зүйн зөвлөгөө ХХК

Бүдрагчаагийн Баяр
Гүйцэтгэх захирал, ЭЗЭЗ ХХК

Дэмчигдоржийн Галсанбуян
Захирал, Төслийн зохицуулагч, ЭЗЭЗ ХХК

ТАЛАРХАЛ

Оролцогчид:

- **Доктор Алберт Гийрэнд**
ҮХЯ/ГТХАН-ийн Төслийн удирдагч, эдийн засагч
Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төсөл
- **Лхагвасүрэнгийн Хулан**
ҮХЯ/ГТХАН-ийн Төслийн менежер
Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төсөл
- **Равдангийн Оюун**
МУ-ын ҮХЯ-ны ахлах ажилтан, БНСУ-ын Сөүл хот дахь МУ-ын ЭСЯ-ны Худалдааны зөвлөх
- **Оросоогийн Пүрэвсүрэн**
ЭЗЭЗ ХХК-ийн Судлаач
- **Ойдовын Бүжинлхам**
ЭЗЭЗ ХХК-ийн Судлаач
- **Алтангэрэлийн Мандуул**
ЭЗЭЗ ХХК-ийн Орчуулагч

Оролцогч байгууллагууд:

Гадаадын болон олон улсын байгууллагууд

- Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГТХАН)
- Европын Холбооны төсөл/Хүнс, хөдөө аж ахуйн яам

Монгол Улсын Засгийн Газрын холбогдох байгууллагууд

- Үйлдвэр, худалдааны яам
- Түлш, эрчим хүчний яам
- Хүнс, хөдөө аж ахуйн яам
- Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв
- Эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн газар, Улсын мэргэжлийн хяналтын газар
- Мал эмнэлгийн газар
- Сүхбаатарын Гаалийн газар, Гаалийн алба
- Эрхүү хот дахь МУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар
- Эрхүү мужийн Эрхүү хот дахь МУ-ын Ерөнхий консулын газар
- Буриадын автономит улсын Улаан-Үүд хот дахь МУ-ын Ерөнхий консулын газар

ОХУ-ын Засгийн Газрын холбогдох байгууллагууд

- Наушкин Гаалийн газар (ОХУ-Монголын хилийн боомт)
- ОХУ-ын Эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн эрүүл мэндийн хяналтын байгууллагын Улаан-Үүд дэх салбар
- ОХУ-ын Мал эмнэлгийн байгууллагын Улаан-Үүд дэх салбар
- Буриадын өөртөө засах орны Эдийн засгийн яам
- Эрхүү мужийн Гаалийн алба, Эрхүү мужийн Улсын стандарт

Оролцогч байгууллагууд (үргэлжлэл):

Холбогдох худалдааны байгууллагууд

- Улаанбаатар төмөр зам
- Дорнын Говь ХХК (махны экспорт)
- Эрдэнэт хивс ХХК (хивсний экспорт)
- Монгол савхи (савхин барааны экспорт)
- Улаанбаатар хивс ХК(хивсний экспорт)
- Монросцветмет ХК (Монгол Оросын үнэт металл) (эрдэс бодисын экспорт)
- Ээрмэл ХХК (ноолуур, ноосны экспорт)
- Завхан ХХК (махны экспорт)
- Эвийн хүч ХХК (махны экспорт)
- ВС Монгол ХХК (махны экспорт)
- Монголын мах экспортлогчдын холбоо
- Бага Хангай ХХК (махны экспорт)
- Говь ХК (ноолуурын экспорт)
- Очир ХК (нүүрсний экспорт)
- Дархан Нэхий ХХК (үслэг эдлэл, савхины экспорт)
- Иволгинск ХХК (махны экспорт)
- Сэргэлэн Оргил ХХК (Оросын худалдааны компани)
- Петровис ХХК (тосны импорт)
- Мон Магнет ХХК (тавилгын импорт)
- Магнай Трейд (тосны импорт)
- Номин Холдинг ХХК (хүнсний импорт)
- Хүрд ХХК (автомашин, мотоциклын импорт)
- Бирюса ХХК (хөргөгчний импорт)
- Юкос Mongolia ХХК (тосны импорт)
- Эрхэс ХХК (автомашин, мотоциклын импорт)

Төрийн бус байгууллагууд

- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
- ОХУ-ын Эрхүү, Улаан-Үүд хотуудад оршин суугч Монгол иргэдийн зөвлөл
- Эрхүү хот дахь Оросын Худалдааны танхим

Зохиогчдын зүгээс зөвлөх, редактор, бизнесийн байгууллагууд, Засгийн газрын ажилтнууд болон худалдааны бодлогын судлаач нарт талархал илэрхийлье.

Монгол-Оросын худалдаан дахь тарифын бус саад тотгор, шаардлагын талаарх судалгааны дүн шинжилгээг ГТХАН-ийн дэмжлэгтэйгээр хийсэн болно.

Доктор Алберт Гийрэнд, ҮХЯ/ГТХАН-ийн Төслийн удирдагч, эдийн засагч

Лхагвасүрэнгийн Хулан, ҮХЯ/ГТХАН-ийн Төслийн менежер

ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Тусгайлан зааснаас бусад тохиолдолд, энэхүү судалгаанд тэмдэглэгдсэн үзэл санаа, байр суурь нь ГТХАН, МУ-ын Үйлдвэр, худалдааны яам, түүнчлэн бусад холбогдох санхүүжүүлэгч байгууллагууд, олон улсын хандивлагч байгууллагууд, Засгийн газрын байгууллагууд болон хуулийн этгээдүүдийнх биш болно.

ХУРААНГУЙ

ОХУ Дэлхийн Худалдааны Байгууллагад нэгдэн орох хэлэлцээг 1995 оноос эхэлсэн бөгөөд энэ хугацаанд тус байгууллагын гишүүн 56 гишүүн улстай тарифын болон үйлчилгээний худалдааны талаарх асуудлаар хэлэлцээрүүдийг явуулж байна. Монгол Улс ОХУ-тай ДХБ-ын хүрээнд 1999 оноос албан ёсны хэлэлцээрүүдийг хийж ирсэн бөгөөд 7 удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулаад байна.

ДХБ-ын хүрээнд Монгол Улс ОХУ-тай барааны тарифын болон тарифын бус саад тотгор, хязгаарлалтыг багасгах, 2 орны худалдааг хөнгөвчлөх, чөлөөтэй болгох зэрэг асуудлаар хэлэлцэж ирсэн. Хоёр улсын худалдааны статистикаас үзвэл, Монгол Улсаас ОХУ-д гаргаж буй экспортын хэмжээ аажмаар буурсан байна.

МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДААНЫ ХЭМЖЭЭ			
<i>ИМПОРТ/ЭКСПОРТ САЯ АМ.ДОЛЛАРААР</i>			
Он	Нийт худалдааны эргэлт	Экспорт	Импорт
2000	251.3	45.1	206.2
2002	273.8	47.9	225.9
2004	362.5	20.6	341.9

2001 оноос хойш Монголоос Орост гаргаж буй экспорт 2 дахин буурч харин Оросоос Монголд экспортолж байгаа бүтээгдэхүүн 1.6 дахин өссөн байна. 2002-2003 онд малын өвчин гарсантай холбогдуулан Оросын мал эмнэлгийн байгууллагаас малын гаралтай экспортын бүтээгдэхүүнд (үхрийн мах, ямааны мах, өлөн, ноос, г.м.) хориг тавьсан нь Монголоос Орост экспортлох махны хэмжээнд ихээхэн нөлөөлсөн байна.

Монголын экспортод үзүүлэх нөлөөллийг судалж үзэхэд Монголоос экспортлох бараанд үйлчилж буй ОХУ-ын худалдааны журам, тэр дундаа өргөн хэрэглэгддэг тарифын бус зохицуулалтын сөрөг үйлчлэлийг нарийвчлан судлах шаардлагатай гэж үзсэн байна.

Мах боловсруулах үйлдвэрлэл болон малын эрүүл ахуйг хангах явдлыг сайжруулах дорвитой арга хэмжээг авахын тулд Монгол Улсын журмыг ОХУ-ын болон олон улсын хүнс болон эрүүл ахуйн стандарттай нийцүүлэх явдлыг дахин харах хэрэгтэй байна.

1999 онд Монгол-Оросын 2 талын худалдааны либералчилалын асуудал эрхэлсэн Ажлын хэсгийг Засгийн газар хоорондын хэлэлцээний Зөвлөлүүдийн дэргэд байгуулсан ба үүнээс хойш нийт 5 удаа уулзаж тарифын бус саад тотгоруудын талаар хэлэлцсэн байна.

1. Судалгааны зорилтууд

- Монголоос ОХУ-д гаргадаг махны экспортод саад учруулдаг ОХУ-ын янз бүрийн тарифын бус саад тотгор, зохицуулалтын өнөөгийн байдлыг задлан шинжлэх
- ОХУ-ын ДХБ-д нэгдэх явц болон хоёр улсын хооронд гадаад худалдааны гэрээ хэлэлцээр байгуулагдах нөхцөлийн хүрээнд зохистой худалдааны хэлэлцээрийн стратегийг боловсруулахад мэдээлэл, зөвлөмжөөр хангах. Үүнд:
 - Монголоос Орос руу гаргахад ногдуулж болох импортын тарифын бус саад тотгор, хязгаарлалтын өнөөгийн байдлыг дараах стандартуудаар гаргаж ирэх:
 - Бараа
 - Захиргааны журмууд
 - Хүнсний аюулгүй байдал
 - Эрүүл ахуйн шаардлага
 - Хамгаалалтын арга хэмжээ
 - Өнөөгийн тарифын бус саад тотгорын үндэслэл, түүнчлэн тарифын бус саад тотгорын талаарх олон улсын стандарт болон ДХБ-ын журамтай тэдгээрийн нийцэж буй байдлыг дүгнэх
 - Монголоос Орос руу гаргах экспортын тарифын бус саад тотгорын нөлөөллийг тоон болон чанарын үзүүлэлтээр тооцох
 - Засгийн газрын бодлогын бичиг баримт, олон улсын судалгаа, худалдааны бодлогын журмыг судлах замаар ОХУ-тай байгуулсан хоёр талын худалдааны хэлэлцээрүүдийг судлан дүгнэх
 - ОХУ-ын ДХБ-д нэгдэх хэлэлцээрүүдийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, ингэхдээ тарифын бус саад тотгор болон худалдааны зохицуулалтыг зөөлрүүлэх, багасгахаар хүлээсэн үүргүүдийг онцгой анхаарах
 - Засгийн газрын ажилтнууд болон судлаачдын зөвлөмж дээр үндэслэн Монгол болон ОХУ-ын хил орчмын нутгуудаар судалгаа хийх
 - Улаанбаатар хот, Дархан, Сэлэнгэ, Завхан аймгуудын төлөөлөгчидтэй дугуй ширээний ярилцлага хийх (Эрдэнэт, 2005 оны 11-р сар)
 - Монгол-ОХУ-ын хоёр талын худалдаан дахь тарифын бус саад тотгор, хязгаарлалтуудыг тодорхой гаргах:
 - Бараанд тавих стандарт
 - Квотын тогтолцоо
 - Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага
 - Импортын лиценз олгох
 - Хүнсний аюулгүй байдлын зохицуулалт, журам
 - Захиргааны болон хамгаалалтын арга хэмжээ

2. Мэдээлэл цуглуулах, үнэлэх дүгнэх үйл явц

Дараах газруудын Засаг захиргааны байгууллага, ЖДҮ болон хувиараа худалдаа, наймаа эрхэлдэг иргэдийг төлөөлсөн 100 гаруй эх сурвалжаас их хэмжээний мэдээллийг цуглуулсан болно.

МУ	ОХУ
Улаанбаатар	Хиагт
Дархан	Улаан-Үүд
Сэлэнгэ	Эрхүү

Эх сурвалжуудыг судалгаанд холбогдох байдлаар нь сонгосон болно. Холбогдох Засгийн газрын хэвлэл, статистикийн мэдээллүүдийг цуглуулж үнэлэлт дүгнэлт өгсөн.

Уг судалгаа нь ОХУ-тай хийсэн хоёр талын худалдааны хэлэлцээрийн талаарх Засгийн газрын бодлогын шинжтэй баримт бичгээс гадна ОХУ-ын худалдааны бодлого, журмын талаарх олон улсын судалгааг ашигласан юм. Энэхүү судалгаанд ОХУ-ын ДХБ-д элсэн орох хэлэлцээрүүдийн өнөөгийн байдлыг харуулсан бөгөөд тарифын бус хязгаарлалт болон худалдааны зохицуулалтыг зөөлрүүлэх, багасгах талаар хүлээсэн үүргийг онцгойлон авч үзсэн. Худалдаанд саад болж буй арга хэмжээнүүдийг олон улсын жишиг, бусад орнуудын худалдааны журмуудтай харьцуулан авч үзсэн болно.

3. Судлагдсан тарифын бус саад тотгор, арга хэмжээний жагсаалт

Барааны стандарттай холбогдох саад тотгорууд

- Бүтээгдэхүүний чанар
- Бүтээгдэхүүний чанарт нөлөөлж болзошгүй үйлдвэрлэлийн арга барил, үйл ажиллагаа
- Бүх гишүүн улсуудад нэн тааламжтай үндэсний нөхцөлийг олгох явдал
- Импортын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгэн адил үзүүлэх нэн тааламжтай үндэсний нөхцөл

Эрүүл ахуйн болон хорио цээрийн стандарттай холбогдох саад тотгорууд

Эрүүл ахуйн шаардлага болон хязгаарлалтууд нь хүмүүс, амьтад, ургамал болон эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан байдаг. Үүнд:

- Төрөл бүрийн шавьж, хортон, өвчин, өвчний эх үүсвэр болон өвчин тээгчид тавигдах шаардлага
- Хүнсний бүтээгдэхүүн болон боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнийг өвчин, нян тээгчээс сэргийлэхэд тавигдах шаардлага
- Халдварт өвчин бүхий амьтан, ургамал, тэдгээрээс халдвар авсан бүтээгдэхүүнээс сэргийлэхэд тавигдах шаардлага

Бараанд тавих хязгаарлалт (хэмжээ болон лиценз)

Импорт, экспорт болон бүтээгдэхүүний үйлчилгээтэй холбогдсон үйл ажиллагаанд тавих хэмжээний болон тусгай зөвшөөрлийн хязгаарлалт.

Захиргааны хязгаарлалтууд

Худалдааны компаниудын заавал биелүүлдэг орон нутгийн захиргааны байгууллагууд болон захиргааны нэгжүүдийн үүсгэсэн тусгай зөвшөөрөл болон бусад хязгаарлалтууд.

ОРШИЛ

1. ДХБ ба ОХУ

ДХБ нь дэлхийн худалдааны дийлэнх хэсэгт хэрэгждэг олон талт гэрээ, хэм хэмжээ, зохицуулалтын нэгдлээс бүрдэнэ. ОХУ-ын ДХБ-д элсэн орох хэлэлцээ нь 1995 оны 4-р сараас эхэлсэн.

1993 оны 6-р сард Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрээс “ОХУ-ын асуудлаарх ажлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд үүнд ОХУ-ын худалдааны бүх түншүүд багтсан ДХБ-ын 60 гишүүн орнууд оржээ. Уг ажлын хэсгийн гол үүрэг нь Оросын эдийн засгийн бодлогыг ДХБ-аас гаргасан хэм хэмжээ, дүрэм журамтай нийцэж буйг тогтоох явдал юм. 1995 оны 7-р сараас хойш нийт 29 удаа уг ажлын хэсэг нь хуралджээ.

Гадаадын компаниуд Оросын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний зах зээлд амархан нэвтрэхээс болгоомжилж буй ОХУ нь олон улсын эрх зүйн зохицуулалттай өөрийн зохицуулалтыг нийцүүлэх, Оросын экспортыг хяхан гадуурхахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шилжилтийн шатанд явж байна.

ОХУ-ын Өнөөгийн “гааль-тариф”-ын бодлогын хууль зүйн эх сурвалж нь ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газар болон тэдгээрийг гүйцэтгэх байгууллагуудын тогтоолууд болж байна. Үүнд:

- Гаалийн татварын тухай тогтоол, 1993 оны 5-р сарын 21
- Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай тогтоол” 1995 оны 10-р сарын 13 болно.

Эдгээр баримт бичгүүд нь Оросын гаалийн татварын бүрдэл, өөрчлөлт, болон хэрэглэх журмыг тодорхойлдог байна.

Импортын гаалийн татварыг барааны боловсруулалтаас нь хамаарч 3 ангилдаг. Үүнд:

- Түүхий эд 0-5%
- Хагас боловсруулсан 5-15%
- Бэлэн бүтээгдэхүүн 15-30%

1995 оны 2-р сарын 28-ны 190-р шийдвэр “Импортын гаалийн татварын үндэслэл, зарчим” нь гаалийн импортын татварын дээд хэмжээг 20% байхаар тодорхойлсон. 2000 оны 1-р сарын 1-ны өдрөөс барааны гаалийн хэмжээ нь үнийн 15% байхаар тогтоожээ (хамгийн доод хэмжээ нь 5%).

ОХУ гаалийн тарифыг дунд, удаан хугацаагаар багасгахдаа зарим тохиолдолд онцгой татварын (дампингийн эсрэг, г.м.) арга хэмжээг хэрэглэдэг.

Гадаад худалдаан дахь тарифын бус зохицуулалт нь орчин цагийн худалдаа болон улс төрийн тогтолцоонуудад үлэмж их үүргийг гүйцэтгэдэг ба уг зохицуулалтыг хэрэглэх явдал ихээхэн түгээмэл болж байна.

ОХУ нь буурай хөгжилтэй орнууд руу чиглэсэн худалдааны таатай нөхцөл үзүүлэх өөрийн тогтолцоотой байдаг. Гаалийн Кодексын 36-р зүйлд зааснаар таатай нөхцөл үзүүлэх тогтолцоог ойролцоогоор 5 жил тутамд хянадаг ба жил тутам Гадаад эдийн засгийн харилцаа болон Гадаад хэргийн яамдууд хянадаг байна. Таатай нөхцөл нь дараах гурван үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд:

- Хөгжиж буй орнуудын жагсаалт
- Хөгжил хамгийн буурай орнуудын жагсаалт
- Таатай нөхцөл үйлчлэхгүй барааны жагсаалт

Одоогоор Ази, Африк, Латин Америкийн 48 гаруй тооны улсын хөгжил хамгийн буурай орнуудын ангилалд багтаж байна.

2. Монгол-Оросын худалдаа

1980 оныг хүртэл Монгол Улсын гадаад худалдаа зөвхөн ЗХУ-аас хамааралтай байсан. ОХУ-аас Монголд импортолж байгаа импортын хэмжээ нь Монголын импортын 33.5 хувийг эзэлж байгаа ба гол импортын бүтээгдэхүүн нь нефтийн бүтээгдэхүүн, үйлдвэрийн тоног төхөөрөмж болон хүнсний бүтээгдэхүүн юм. Монгол Улс ОХУ-тай ДХБ-ын хүрээнд 1999 оноос хойш албан ёсны 11 удаагийн гэрээ, хэлэлцээрүүдийг хийж ирсэн бөгөөд эдгээр нь дараах асуудлуудыг онцгойлон авч үзэж байв. Үүнд:

- Барааны тарифын болон тарифын бус хяналтыг багасгах
- Чөлөөт худалдаа
- Саад тотгорууд
- Хязгаарлалтууд ба либералчилал

2005 оны 4 дүгээр сард Монгол-Оросын хоёр талын ээлжит 8 дахь хэлэлцээ Женев хотноо болсон байна. ОХУ 600 орчим нэрийн бараа бүтээгдэхүүнд тарифын санал ирүүлснээс Оросын зах зээлд нийлүүлэгдэж болох манай 100 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дээр түлхүү анхааран хэлэлцээ хийжээ. ОХУ-ын анхны санал нь одоогийн мөрдөгдөж байгаа барааны дундаж тарифаас 50%, үүний дотор ХАА-н гаралтай барааны тариф нь 100% өндөр байжээ. Олон удаагийн хэлэлцээ хийсний үр дүнд нийт барааны дундаж тариф 13 хувь, үүнээс ХАА-н барааны дундаж тариф 12% байхаар тохирсон болно. Мөн тохиролцоот тарифт хүрэх шилжилтийн хугацааг дунджаар 2.2 жил байхаар тохиролцжээ. ОХУ нь Дэлхийн Худалдааны Байгууллагад орсны дараах шилжилтийн үедээ импортын дундаж татварыг 7.5-д хүргэхээр амлаад байна. Аж үйлдвэрийн бараандаа 5% байх бол ХАА-н бүтээгдэхүүнд өөрчлөлт орохгүй юм байна. ОХУ өөрийн экспортын бараанд ногдуулах татвараа аажмаар бууруулж, улмаар ДХБ-д нэгдэн орсноос хойш 4 жилийн дотор экспортын татвараа тэглэхээ амлажээ. Гэхдээ газрын тосны, түлш-эрчим хүчний бүтээгдэхүүнүүд болон хар, өнгөт металлын хаягдал гэх мэт чухал түүхий эдийн экспортын татварыг хэвээр байлгана гэжээ.

ОХУ болон Монгол Улс нь ОХУ-ын ДХБ-д нэгдэн орохтой холбогдсон 2 талын хэлэлцээрийг 2005 оны 10-р сарын 5-нд дуусгаж, албан ёсны тэмдэглэлд гарын үсэг зуржээ. Үүнд ОХУ-ын талаас Эдийн засаг, худалдааны сайд Оскарович Греф, Монголын талаас Үйлдвэр, худалдааны сайд С. Батболд нар гарын үсэг зурсан байна.

Өнөөгийн худалдаанд дараах эерэг болон сөрөг үзэгдлүүд байна. Үүнд:

- 2 улсын хооронд худалдаа хийхэд худалдааны төлбөрийн тооцоо шууд бус гуравдагч орны банкаар дамжуулан хийгдэх болсон.
- ОХУ дотоод зах зээлээ хамгаалах зорилгоор:
 - Импортын тарифыг өндөр тогтоосон
 - Квот тогтоосон
 - Мал эмнэлгийн шаардлагыг өндөрсгөсөн
- 2 улсын тухайн байгууллагуудын хооронд хэлэлцээр, зөвшилцлүүд шинээр сайн хийгдээгүй байсны улмаас 2 улсын хоорондын худалдаанд худалдааны вакуум (орон зай) үүссэн.
- Монгол Улсын худалдааны гол түнш нь Сибирээр хязгаарлагддагын улмаас үнийн чөлөөт өрсөлдөөн явагдах боломжгүйд хүргэдэг.
- Оросын импортлогчид дараа төлбөрийн хэлбэрээр махаа худалдаж авдаг нь төлбөр хугацаандаа төлөгдөхгүй байх үндсийг бий болгодог.
- Монголтой хил залгадаг нутгуудад махны хангамж хэрэгцээт хэмжээнээс маш доогуур байдаг, үүнээс болж махны жижиглэнгийн үнэ 1кг нь 4-7 америк доллар хүртэл өсдөг.
- Нефтийн импортын гол хүндрэлтэй асуудал нь тээврийн өндөр өртөг, Оросын экспортын гаалийн татварууд, нефтийн бүтээгдэхүүнд тавих монополи эрх байдаг.
- Гаалийн бүрдүүлэлт хийх ажиллагааны хугацаа маш удаан, хүнд суртал ихтэй байна.
- Оросын Засгийн газар, захиргааны ажилтнуудын дунд орших хээл хахууль, авилгал, гэмт хэрэг.
 - Энэ нь нэн ялангуяа жижиглэнгийн наймаачдад их хүндрэл учруулдаг.

Өнөөгийн худалдаан дахь сөрөг үр дагавруудыг дэлгэрүүлэн тоочвол:

- ОХУ нь 60 мянган тонн монгол махыг экспортлох нөөц бололцоотой хэдий ч Бурмяспром нь ОХУ-аас тогтоосон махны квотын дийлэнхийг эзэмшдэг байна. Энэ байдал нь Монголын мах экспортлогч компаниуд нь махыг олон улсын жишгээс доогуур үнээр ОХУ-д худалдаалахад хүргэдэг. Квотоос давсан хэмжээний махны импортод 60%-ийн импортын татварыг ногдуулж байгаа нь нилээд өндөр байна.
- Одоогийн байдлаар Алтанбулаг, Сэлэнгийн 200-300-аад иргэд, Хиагтын 50-100-аад орос иргэд жижиг худалдаа эрхлэн Монголоос өргөн хэрэглээний бараа, хувцас, Оросоос хоол хүнсний зүйлс зөөж байна.
- Энэ барааны өртөг нь хориос зуун доллар хүртэлх хэмжээний үнэтэй байгаа боловч гаалийн зүгээс их хатуу шаардлага тавьдаг.
- ОХУ-ын Гаалийн ажилтнууд түүнчлэн дамжин өнгөрөх тээвэрлэлтэд хүндрэл учруулдаг. Ачааны мэдүүлэг бага зэрэг зөрүүтэй байгаагаар шалтаглан барааг хураан авдаг. Оросын Төмөр замын албанаас хэрэгжүүлдэг эдгээр бодит байдалд үл нийцэх арга хэмжээ нь төмөр замын худалдааны эргэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Тарифын болон тарифын бус саад тотгоруудыг даван туулах дараах арга хэмжээг санал болгож байна. Үүнд:

- Монголын махны экспортын квотыг нэмэгдүүлэх
- Монголын махыг эрүүлжүүлэх асуудалд хамтран ажиллаж Монголоос Орос руу экспортоор орж байгаа махыг “Д” зэрэглэлд багтаан оруулах
- Монгол махыг хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн хэлбэрээр гаргах
- Монгол малын дайвар бүтээгдэхүүний экспортыг хэмжээг нэмэгдүүлэх
- Хонь, ямааны махны экспортыг нэмэгдүүлэх
- Хилийн худалдааг нэмэгдүүлэх
- Хил орчмын байгалийн баялгийг ашиглах төслүүдийг хамтран хэрэгжүүлэх
- Хил орчим Оросын түүхий эд дээр тулгуурласан АНУ, Европын Холбооны хамтарсан үйлдвэрүүдийг бий болгох
- ОХУ-аар дамжин өнгөрч буй тээвэрлэлтийн хязгаарлаж буй саад тотгоруудыг арилгах
- ОХУ, Монгол Улсын хооронд бий болох боломжтой аялал жуулчлалын нөөц бололцоог ашиглах
- Улаан-Үүд, Эрхүү хотуудад Монголын Худалдааны төвүүдийг байгуулах

Манай хоёр орны хооронд мэдээлэл, харилцааны салбар нь зохих хэмжээнд байхгүй байгаагийн улмаас мэдээлэл, бизнесийн орон зайг үүсгэж байна. Хоёр орны Худалдааны танхимууд, бизнес болон олон нийтийн байгууллагуудын хоорондын харилцааг улам сайжруулснаар ижил стандарт бүхий ойролцоо худалдааны практикийг бий болгох боломжтой юм.

ОХУ-ЫН ДХБ-Д НЭГДЭН ОРОХ ҮЙЛ ЯВЦ

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2001 онд ДХБ-д элсэхтэй холбогдуулан авах бүхий л арга хэмжээ нь зөвхөн ОХУ-ын үндэсний эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс хийгдэх болохыг тунхагласан билээ. Тэрээр хэлэхдээ:

“Бид, ямар ч тохиолдолд ДХБ-д стандартын бус нөхцөлөөр нэгдэхийг хэрхэвч зөвшөөрөхгүй” гэжээ.

“Стандартын бус нөхцөл” гэдэгт ДХБ-д нэгдсэнээс үүсэн бий болох давуу талаас үл хамаарч, гадаадын зах зээлүүдтэй өрсөлдөхөд бэлэн бус байгаа Оросын эдийн засгийн өрсөлдөх нөөц бололцоо бүхий салбаруудыг ашиглах бүхий л оролдлого хамаарна.

1992 онд, ОХУ нь Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр (ТХЕХ)-т ажиглагчийн эрхийг авсан бөгөөд энэ эрхийг хуучин ЗХУ-аас залгамжлан авсан байна. 1994 оны 12-р сард ОХУ нь ДХБ-д элсэн орох албан ёсны хүсэлтээ өргөн барьсан. Улсын Дум зохих хууль тогтоомжийг 1995 оны 4-р сард баталсан.

Хэлэлцээний эхний “мэдээллийн” шинжтэй үйл явц нь Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээрээс байгуулсан “ОХУ-ын асуудлаарх ажлын хэсэг” байсан бөгөөд үүнд, ОХУ-ын худалдааны бүх түншүүд багтсан ДХБ-ын 60 гишүүн орнууд оржээ. Уг ажлын хэсгийн гол үүрэг нь Оросын эдийн засгийн бодлогыг ДХБ-аас гаргасан хэм хэмжээ, дүрэм журамтай нийцэж буйг тогтоох явдал юм (2-р Хавсралтыг үзнэ үү).

Хэлтэс хоорондын комисс (1993 онд ДХБ-тай үйл ажиллагаагаа нийцүүлэх зорилгоор байгуулагдсан)-ыг 1997 онд “ДХБ-ын асуудал эрхэлсэн ОХУ-ын Засгийн газрын комисс” болгон өөрчлөн байгуулжээ. Үүнд ойролцоогоор 50 орчим холбооны сайд нар, алба, байгууллагууд хамаардаг байна.

Эдийн засгийн хөгжил, худалдааны яам нь уг комиссын үйл ажиллагааг зохицуулдаг. Одоогийн хэлэлцээрүүд нь Оросын зах зээл дээр гадаадын бараа, үйлчилгээг бий болгох асуудалд анхаарч байна.

ОХУ-ын Засгийн газрын холбогдох албад 10 гаруй албан ёсны болон судалгаа, шинжилгээний баримт бичгийг боловсруулаад байна. Үүнд хамрагдсан дараах сэдэв байна:

- Хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлэх дотоодын тогтолцоонууд
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд үйлчлэх тарифын болон тарифын бус зохицуулалтууд
- Импортын болон экспортын барааны үнийг тодорхойлох гаалийн аргачлалын систем
- Гадаад эдийн засгийн зохицуулалтын эрх зүйн орчныг хөгжүүлэх

1. Давуу болон сул талууд

ДХБ-ын гишүүн орнууд Оросын дараах өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний зах зээлд гадаадын компаниуд амархан нэвтрэх аюулын талаар байнга хөндөж хэлэлцдэг билээ. Үүнд:

- Хөдөлгөөнт үүрэн харилцаа холбооны зах зээл, үйлчилгээ
- Банкны үйлчилгээ
- Хүнсний үйлдвэрлэл
- Даатгалын үйлчилгээ
- Механик, инженер
- Иргэний агаарын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл
- Төмрийн металлурги
- Хөнгөн цагааны үйлдвэрлэл

Дараах асуудлуудад анхаарлаа хандуулах тохиолдолд ОХУ шилжилтийн үед хүрэх боломжтой. Үүнд:

- Санхүүжилтийн хүндрэлүүдийг арилгах
- ОХУ-ын хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэх
- Зээлийн эрсдэлийг багасгахтай холбогдсон эдийн засгийн ил тод байдлыг хангах

Барууны банкнуудын нөлөө нь санхүүгийн үйлчилгээний зах зээлийн өрсөлдөөнийг эрчимжүүлж, илүү хямд зээлийн эх үүсвэрт хүрэх бололцоог нээж өгнө.

2. Эерэг талууд

- Олон улсын эрх зүйн орчинд нэгдэнэ.
- Бусад орнууд ОХУ-ын экспортыг хяхан ялгаварлахаас хамгаална.
- Үйлчилгээний шинэ зах зээлд нэвтэрнэ.
- Олон улсын худалдаанд зориулсан шинэ журмууд боловсрогдоно.
- ОХУ-ын хууль тогтоомж олон улсын хэм хэмжээтэй нийцнэ.
- Хууль батлахад үйлдвэрлэлийн салбар, орон нутгийн бүсээр лоббидох явдал багасна.

3. Сөрөг талууд

- Олон үйлдвэрлэгчид гадаадын өрсөлдөөнийг сөрөхөд хамгаалалт, баталгаагүй болно
- Импортын татвараас төсөвт оруулах орлого багасна
- Тарифын либералчилал
 - Гадаадаас орж ирэх импорт илүү их анхаарал татна
 - Үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт татах нь багасна
- ДХБ нь ОХУ-ын барааны дампингийн эсрэг арга хэмжээг баталгаажуулахгүй

ОЛОН УЛСЫН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ ОХУ-ЫН БОДЛОГОТой УЯЛДУУЛАХ НЬ

1. Олон улсын худалдааны тарифын зохицуулалт

Олон улсын тарифын зохицуулалт нь олон улсын худалдааны үйл явцыг зохицуулдаг нэгдмэл зарчим, хэм хэмжээнд тулгуурладаг. Зохицуулалт нь дараах байгууллагуудын үйл ажиллагаанаас үүсэн бий болжээ. Үүнд:

- Дэлхийн Гаалийн Байгууллага
- Европын Эдийн Засгийн Комисс
- НҮБ
- ДХБ
- Худалдаа, Хөгжлийн талаарх НҮБ-ын Бага Хурал

Дийлэнх орнуудын тарифын зохицуулалтад Гаалийн татварын тухай хууль болон Гаалийн кодексууд нь эрх зүйн үндсэн эх сурвалж болдог. Үндэсний эрх зүйн баримт бичиг болох Гаалийн кодекс нь олон улсын хэлэлцээнд хамаардаггүй. Харин гаалийн татвар нь олон улсын дүрэм, журмуудаар зохицуулагддаг ба олон улсын хэлэлцээнд тогтмол хөндөгддөг. Эдгээр хэлэлцээнүүд нь бараанд оногдуулах тариф, тэдгээрийн бүтэц, түвшин, хэмжээ, экспорт, импортод оногдуулах хэмжээ зэргийг жагсаадаг.

Гаалийн татвар нь тухайн орны эдийн засгийн хөгжил болон тарифын импортын татварын хэмжээний харилцан хамаарлыг тогтоож байдаг. Аливаа улс хөгжингүй байх тусам татварын хэмжээ бага байдаг (өөрөөр хэлбэл тухайн улсад хангалттай хэмжээний үйлдвэрлэлийн өрсөлдөөн буй, тиймээс татварын хамгаалалт төдийлөн шаардлагагүй байдаг). Унгар, Австри, болон Швейцарь улсуудад гаалийн татвар дунджаар тус тус 16.8-аас 3% байдаг байна.

Гэсэн хэдий ч, тансаг хэрэглээний барааны татварын хэмжээ нь дундаж барааныхаас хамаагүй илүү байх боломжтой бөгөөд, тухайн улсын санхүүгийн хүүгээс л шалтгаалдаг байна. Европын Холбоонд барааны дундаж тариф нь 4% хүрэхгүй байхад, архины импортын татвар 20%-аас хэтэрдэг, түүнчлэн загасны түрсний тариф 30% байдаг байна.

Өнөөгийн тарифын зохицуулалтад нь импортын гаалийн татвар аажмаар багасгах хандлагатай байна. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд оногдуулах татварын дундаж хэмжээ нь 5% арай хүрэхгүй байна. Тарифын хэмжээ багасгах явдал ирээдүйд үргэлжлэх болно. Гаалийн татварыг хоёр ангилж болж байна:

Импортын тариф:

- Импортын тариф нь аливаа улсын гадаад худалдааны хэмжээг зохицуулах үндэс нь болдог. Үүнийг 100 гаруй орнуудад хэрэглэдэг.
- Импортын тариф нь импортолсон барааны үнийг нэмэгдүүлдэг учраас зорилтот зах зээл дээрх өрсөлдөөнийг хязгаарладаг
- Импортын татвараар хамгаалагдсан барааг үйлдвэрлэгчид өргөн хэрэглээний барааны зах зээл өргөжиж өөрийн бараа нэмэгдсэнээс ашиг олдог.

Экспортын тариф:

- Экспортын тарифыг байгалийн баялагт хэрэглэдэг хязгаарлагдмал тооны улсууд байдаг
- Байгалийн нөөц баялаг ихтэй хөгжиж буй орнууд нь дотооддоо хямд үнэ, гадаадад өндөр үнийг тогтмол барихын тулд экспортын тарифыг хэрэглэдэг.
- Экспортын тарифыг улсын мөнгөн тэмдэгтийн нөөцийг нэмэгдүүлэхэд ашигладаг.
- Гэсэн хэдий ч, экспортын тариф нь экспортын бүтэц болон хэмжээнд сөрөг эдийн засгийн үр дагаврыг авчирч болзошгүй байдаг
 - Тухайн улсын экспортын нөөц бололцоог сулруулах
 - Гадаад худалдааны хэмжээнд зөрчил бий болгох, үүнээс инфляци үүсгэх.

2. ОХУ-ын гаалийн болон тарифын бодлогын хөгжил

ОХУ-ын Өнөөгийн “гааль-тариф” бодлогын хууль зүйн эх сурвалж нь ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газар болон тэдгээрийг гүйцэтгэх байгууллагуудын тогтоолууд болж байна. Үүнд:

- Гаалийн татварын тухай тогтоол, 1993 оны 5-р сарын 21
- Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай тогтоол” 1995 оны 10-р сарын 13

ОХУ-ын гаалийн татварын үндсэн зорилгыг ихэнхдээ дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Өргөн хэрэглээний барааны импортыг дэмжих
- Үндэсний үйлдвэрлэл болон хэрэглээний хөгжлийн нөхцөл
- Гадаадын шударга бус өрсөлдөөнөөс Оросын зах зээлийг хамгаалах
- ОХУ олон улсын эдийн засгийн байгууллагуудад нэгдэн орох нөхцөл
- Төлбөрийн тэнцлийн бүтцийн сайжруулалт

Импортын гаалийн татварыг барааны боловсруулалтаас хамаарч 3 ангилдаг. Үүнд:

- Түүхий эд 0-5%
- Хагас боловсруулсан 5-15%
- Бэлэн бүтээгдэхүүн 15-30%

Оросын тариф нь дийлэнх улс орнуудад хэрэглэдэг зарчмыг баримталдаг. Үүнд:

- Нэмэгдэх тариф-Барааны боловсруулалт, үйлдвэрлэлийн түвшнээс хамаарч татварын хэмжээ нэмэгдэх
- Үр нөлөө бүхий тариф-үйлдвэрлэлийн хөгжилд шаардлагатай барааны багассан татвар

1995 оны 2-р сарын 28-ний 190-р шийдвэр “Импортын гаалийн татварын үндэслэл, зарчим” нь гаалийн импортын татварын дээд хэмжээг 20% байхаар тодорхойлсон. 2000 оны 1-р сарын 1-ний өдрөөс барааны гаалийн үнийн 15% байхаар тогтоожээ (хамгийн доод хэмжээ нь 5%).

Татварын хэмжээнд огцом өөрчлөлт орохоос сэргийлж ОХУ-ын Засгийн газрын 1997 оны 10-р сарын 1347-р шийдвэр тарифын тогтолцоог улам тогтворжуулсан. Уг шийдвэрээр татварын хэмжээг 6 сарын зайтай өөрчилж болох төдийгүй өөрчлөгдсөнөө хойш 180 хоногийн дараа үйлчлэх хүчин чадалтай болох бөгөөд нэг удаад 10%-аас илүү хэмжээгээр өөрчлөхийг хориглосон байна.

Татварын хэмжээг үндэсний үйлдвэрлэгчдийн экспортын өрсөлдөөнийг эрчимжүүлэх зорилгоор өөрчилж болно. Дараах тоон харилцан хамаарал байж болох:

- Экспортын барааг нэмэгдүүлсэн тохиолдолд түүхий эд болон үндэсний үйлдвэрлэлийн бусад хэрэгсэлд оногдуулах импортын татварын хэмжээ багасна.
- Бэлэн бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг худалдааны буюу улс төрийн зарчимд тулгуурлан багасгах боломжтой
- Дунд болон урт хугацааны хувьд тарифын хамгаалалтыг багасгах явдлыг хэмжээний хязгаарлалт болон онцгой татвараар (дампингийн эсрэг, г.м.) нөхөх хэрэгтэй гэж ОХУ үзэж байна.

3. ОХУ-ыг ДХБ-д элсэхтэй холбогдсон тарифын бодлого

ОХУ-ын ДХБ-д элсэх явдал нь дотоодын гаалийн татварын хөгжилд чухал нөлөө үзүүлэх болно. ДХБ-ын гишүүн болох чухал элемент бол улсын эдийн засгийн үр нөлөө бүхий тарифын хамгаалалтад үндэслэсэн тарифын буулт юм. Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээр/Дэлхийн Худалдааны Байгууллагын хүрээнд өргөн хэрэглээний барааны нилээд хэсэг нь гаалийн татвартай холбоотойгоор “холбоотой байр суурь”-ийн статустай байна. Тарифын хамгаалалтын тусгай зарчмууд нь өргөн хэрэглээний барааны байр суурийг 3 бүлэгт хуваах боломжтой болгож байна. Үүнд:

1. Урт хугацаанд Засгийн газрын идэвхтэй дэмжлэг шаардагддаг үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болон улсын аюулгүй байдлыг хангадаг бүтээгдэхүүн. Энэ бүлгийн ерөнхий/түгээмэл хэрэглээний барааны 13-15%-д тарифын холболтыг хассан байна.
2. Импортод мэдрэмтгий, Засгийн газраас дэмжлэг шаардагддаг үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн. Энэ бүлгийн барааны 35% орчим хувьд нь тарифын илүү өндөр хэмжээ тогтоохын тул тарифын холболт шаардлагатай байдаг.
3. Импортод мэдрэмтгий биш, Засгийн газраас тодорхой дэмжлэг шаарддаг үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн хамаарна. Энэ бүлгийн барааны 50% орчим хувьд нь тарифын тогтмол хэмжээ тогтоохын тулд тарифын холболт шаардлагатай байдаг.

Тарифын холболт нь гадаадын нийлүүлэгчид болон Оросын импортлогчдод аль алинд нь тогтвортой таамаглахуйц байдлыг ОХУ-ын тарифын тогтолцоонд бий болгоно. Энэ нь худалдааны эргэлтийг эрчимжүүлэх чухал хүчин зүйл юм.

4. Олон улсын худалдааны тарифын бус зохицуулалт

Гадаад худалдааны зохицуулалтын тарифын бус хэрэгсэл нь өнөөгийн худалдаа, улс төрийн механизмд чухал үүрэг гүйцэтгэдэг болоод байна.

Тарифын бус хэрэгсэл нь олон улсын худалдаанд ерөнхийдөө хэр зэрэг нөлөөлдөг нь тодорхойгүй байна. Тоон дүгнэлтийг хийх боломжгүй байна. Тарифын зохицуулалтыг хууль тогтоомжоор бий болгодог бол тарифын бус хязгаарлалтыг гүйцэтгэх эрх мэдлийн төв болон орон нутгийн салбарууд хийх боломжтой байдаг. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын мэргэжилтнүүд тарифын бус хязгаарлалтын нийт хэмжээ нь дотоодын татварын арга хэмжээний 20 хүртэлх хувийг, түүнчлэн батлагдсан дүрэм, журмуудын 20 орчим хувийг эзэлдэг хэмээн дүгнэжээ. АНУ, Япон болон Европын Холбоо зэрэг орнууд нь гадаад худалдааны тарифын бус хязгаарлалтын хэрэглээгээрээ тэргүүлдэг байна.

Тарифын бус зохицуулалтын олон улсын практикт дараах цөөн тохиолдлыг хэрэглэдэг байна. Үүнд:

- Үндэсний эдийн засгийг хамгаалах
- Олон улсын аюулгүй байдлыг хангах
- Хүн амын амьдрал, эрүүл мэндийг хамгаалах
- Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх
- Олон улсын худалдааны тогтолцоог тогтворжуулах

5. Олон улсын худалдаанд харилцан тохиролцсон тарифын бус зохицуулалтыг хэрэглэх явц дахь олон улсын эрх зүйн тогтолцоо

Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээр/ДХБ-ын хүрээн дэх худалдааны зохицуулалтын олон улсын эрх зүйн тогтолцоо нь үл ялгаварлал болон зах зээлийн үр нөлөөтэй байдалд тулгуурладаг. Тарифын бус хэрэгслийг хэрэглэх явдлыг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

1. Тарифын бус зохицуулалт нь олон улсын эрх зүйн дараах зарчмуудын дагуу хэрэглэгддэг. Үүнд:
 - Импортлогч орны дотоодын зах зээл дээр уг бараа байх
 - Импортлогч орны дотоодын зах зээл дээрх уг барааны статус
 - Тарифын бус зохицуулалтад зориулсан ил тод хууль зүйн үндэслэл байх
 - Дамжин өнгөрөх эрх чөлөө
2. Тарифын бус зохицуулалтын хэрэгслийг хэрэглэх явдлыг тоон хязгаарлалтын бүхий л хэлбэрийн хориглолтоор хязгаарлах.
3. Тарифын бус зохицуулалтын хэрэгслийг хэрэглэх явдлыг олон улсын дүрэм, болзошгүй/цаашид бий болох ялгаварласан буюу протекционист шинжтэй журам, тарифын бус зохицуулалтыг хориглох замаар хязгаарлах (тухайлбал, гаалийн болон хилийн тусгай журам, техникийн шинжтэй саад тотгорууд, эрүүл ахуйн арга хэмжээ зэргийг хэрэглэх, г.м.).
4. Тарифын бус зохицуулалтыг олон Засгийн газрууд тэнцвэржүүлэхийн тулд дараах цогц хүчин зүйлсийг нарийн зохицуулагдсан механизмаар бүрдүүлэх. Үүнд:
 - Импортлогч талыг шударга бус худалдааны практикаас хамгаалах
 - Зах зээл дэх гэнэтийн өөрчлөлт (дампингийн эсрэг арга хэмжээ, хамгаалалтын арга хэмжээ, тэнцвэржүүлэх татвар, болон харилцан хоёр талын арга хэмжээ, г.м., Хавсралт 3-ийг үзнэ үү)
 - Үндэсний үйлдвэрлэл дэх онц байдал
 - Байгалийн болон ослын хүчин зүйл, үйл явдал
 - Хүн амын аюулгүй байдлын шаардлага
 - Нутгийн хэм хэмжээ, ёс суртахууныг дагаж мөрдөх

6. ОХУ ба ДХБ: Хөдөө аж ахуйн байдал

“Хөдөө аж ахуйн гэрээ” нь ДХБ-ын гишүүн орнуудыг худалдааны шинэ нөхцөл байдалд дасахад үндэсний хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үүсэж болох сөрөг үр дагаврыг арилгахад шаардагдах шилжилтийн урт хугацааг шаардаж байна. ОХУ зэрэг холбогдох улс орнууд нь энэхүү шилжилтийн үеийг ашиглаж олон улсын худалдааны шинэ давуу талыг үндэсний хөгжилдөө эерэгээр ашиглах боломжтой юм. ОХУ нь хөдөө аж ахуйд үзүүлэх Засгийн газрын дэмжлэг сулрахаас болгоомжлох хэрэгтэй юм.

Олон улсын худалдааны хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт нэгдэх явдал нь хамгаалалтын арга хэмжээг шууд арилгах боломжтой гэсэн үг биш юм. ДХБ-ын зарим шинэ орнууд хуучин журмуудаа баримтлах шаардлагатай байж болзошгүй юм. Тиймээс, олон улсын зүгээс үзэхэд хамгийн хөгжих ирээдүйтэй үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхийг чухалчлах нь зүйтэй.

ДХБ-д элсэх явдал нь ОХУ-д дотоодын зах зээлийг хамгаалах тарифын бус арга хэмжээнээс тарифын зохицуулалтад шилжих шаардлагыг бий болгож байгаа юм. Энэ шилжилт нь дараахыг шаардаж байна. Үүнд:

- Төрөл бүрийн импортын хүнсний зүйлст гаалийн шинэ татварыг ногдуулах
- Дотоодын бүтээгдэхүүний НӨАТ-ыг багасгах
- ОХУ-ын гаалийн татварыг одоогийн хэмжээнээс бууруулах
- Оросын эдийн засгийн тогтворшил болон цаашдын хөгжил нь хүнсний зүйлсийн эрэлт, хэрэгцээг нэмэгдэхэд хүргэнэ
- Импортын татварыг багасгах нь импортын бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлнэ.

7. Эрүүл ахуйн арга хэмжээг ашиглах талаарх гэрээ

Уг Гэрээ нь Засгийн газрууд эрүүл ахуйн арга хэмжээг хэрэглэх эрх зөвхөн ард түмэн, амьтан, ургамлын амьдрал, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай тохиолдлоор хязгаарлагдахыг хүлээн зөвшөөрдөг.

Эрүүл ахуйн арга хэмжээг зохицуулж нэгтгэхийн тулд ДХБ-ын гишүүн орнууд нь олон улсын стандартыг хэрэглэх үүргийг үүсгэж байна. Олон улсын стандартаас хэтэрсэн эрүүл ахуйн шаардлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй буюу ДХБ-ын гишүүн орон ач холбогдлыг нь тодорхойлж чадвал хэрэглэж болно. Ач холбогдлыг нь тодорхойлохдоо хүний, амьтны, ургамлын амьдралд нүүрлээд буй эрсдэлийн тооцоонд үндэслэж болно. Экспортлогч орнууд нь импортлож буй оронтой нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний ижил түвшинд байх ёстой. “Гэрээ” нь хяналт, шалгалтын явцын журмуудыг багтаасан байна.

Гэрээнд эрүүл ахуйн арга хэмжээний зохицуулалтад ил тод байх шаардлагыг тавьдаг ба үүнд холбогдох эрх зүйн акт нь урьдчилан хэвлэгдсэн байх, түүнчлэн үндэсний мэдээллийн сүлжээ байгуулах, мэдэгдэх журам зэрэг шаардлагыг тавьсан байдаг. Уг мэдээллийн сүлжээ нь ДХБ-ын гишүүдийн лавлагаанд хариу өгч тэдгээрийг баримтжуулах ёстой байна. Түүнчлэн уг Гэрээ нь Эрүүл ахуйн арга хэмжээний комисс байгуулах шаардлагыг тавьдаг ба энэ нь аливаа зөвлөлдөөн, бусад холбогдох байгууллагатай холбогдох цэг болж олон улсын хамтын ажиллагааг зохицуулах, хянах үүрэгтэй байх юм.

8. ОХУ-ын үндэсний таатай нөхцөл үзүүлэх тогтолцоо

Таатай нөхцөл үзүүлэх явдал нь эдийн засгийн үр нөлөө бүхий бодлого ба өргөн хэрэглээний барааны зах зээл, түүхий эдийн эх үүсвэр, капиталын хөрөнгө оруулалтыг бэхжүүлэхэд хэрэглэгддэг. Таатай нөхцөл үзүүлэх тогтолцоо нь

“Хөгжил буурай орнуудын барааны гарал үүслийг тарифын таатай нөхцөл үзүүлэх замаар тодорхойлох нэгдсэн дүрмийн талаарх Гэрээ”-ний зохицуулалтад тулгуурладаг.

Уг Гэрээг 1980 онд Болгар, Унгар, Польш, ЗХУ, Чехословак зэрэг орнуудын Засгийн газрууд байгуулсан.

Гаалийн татварын тухай хуулиудын 34-р зүйлээс үзэхэд, тарифын таатай нөхцөл нь ОХУ-ын гаалиар орж ирэх бараанд харилцан үзүүлэх нөхцөлтэйгөөр олгох эрх ямба юм. Энэ тарифын таатай нөхцөл үзүүлж буй явдал нь уг барааг өмнө нь татвараа бүрэн төлсөн, татвараас чөлөөлөгдсөн, татварыг хорогдуулан төлсөн буюу импорт, экспортын таатай нөхцөлийг хүлээн авагч нь бараанд оногдуулсан тарифын квотыг төлсөн зэргийн аль нэгийг илэрхийлж байгаа юм.

36-р зүйлээс үзэхэд, тарифын таатай нөхцөлийг дараах бараанд үзүүлж болохоор байна. Үүнд:

- Хөгжиж буй орнуудын бараа
 - ОХУ-ын үндэсний таатай нөхцөл үзүүлэх тогтолцооны хэрэглэгчид буюу хүлээн авагчид. Эдгээр улсуудын бараа нь үйлчилж буй татварын хэмжээний 75%-тай тэнцэх хэмжээний татварыг төлж байна
- Хөгжил хамгийн буурай орнуудын бараа
 - ОХУ-ын үндэсний таатай нөхцөл үзүүлэх тогтолцооны хэрэглэгчид буюу татваргүй импортын таатай нөхцөл хүлээн авагч орнууд
- Чөлөөт худалдааны бүс, гаалийн нэгдлүүд, чөлөөт худалдааны бүсийг ОХУ-тай хамтран байгуулахаар тохиролцсон гэрээний оролцогч улсын бараа

ОХУ нь буурай хөгжилтэй орнуудад чиглэсэн худалдааны таатай нөхцөлийг үзүүлэх өөрийн тогтолцоотой байдаг. Гаалийн кодексын 36-р зүйлд зааснаар таатай нөхцөл үзүүлэх тогтолцоог ойролцоогоор 5 жил тутамд хянадаг ба жил тутам Гадаад эдийн засгийн харилцаа болон Гадаад хэргийн яамдууд хянадаг байна. Таатай нөхцөл нь дараах гурван үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд:

- Хөгжиж буй орнуудын жагсаалт
- Хөгжил хамгийн буурай орнуудын жагсаалт
- Таатай нөхцөл үйлчлэхгүй барааны жагсаалт

Одоогоор Ази, Африк, Латин Америкийн 48 гаруй тооны улс нь хөгжил хамгийн буурай орнуудын ангилалд багтаж байна. ОХУ-ын Засгийн газрын 1996 оны 1095-р шийдвэрийн дагуу Босни, Герцеговинаг хөгжиж буй орнуудын жагсаалтад нэмж оруулсан ба энэ ангилалд хүн амд ногдох орлогын хэмжээ бага, нийгмийн асуудал их орнууд багтдаг байна.

МОНГОЛ-ОХУ-ЫН ХУДАЛДААНД УЧИРЧ БУЙ ТАРИФЫН БУС СААД ТОТГОРУУД

1. Монгол-Оросын худалдааны өнөөгийн байдал

1980 он хүртэл хуучнаар ЗХУ нь манай гадаад худалдааны гол түнш байсан төдийгүй манай гадаад худалдаа зөвхөн энэ улсаас хамааралтай байсан. 1990 онд Монгол Улс ардчилсан замыг сонгон, төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан Оросын Холбооны Улстай хийж байсан худалдаа 1.23 тэрбум ам.доллар байсан нь манай худалдааны нийт эргэлтийн 80 орчим хувийг эзэлж байжээ. Монгол Улс худалдааг харьцангуй либералчилж, манай гадаад худалдааны хүрээ тэлэгдэж, экспорт, импортын бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон.

Монгол-Оросын худалдааны хэмжээ			
Он	Сая ам.долл	Экспорт	Импорт
2004	362.6	20.6	341.9
2003	306.6		
2000	251.3		

Экспорт, импортын хэмжээний зөрүү нь Оростой хийх худалдаанд тэнцвэргүйжилт байгааг харуулж байна


2004 оны байдлаар манай хоёр улсын худалдааны нийт эргэлт нь 362.6 сая ам.доллар байгаа нь 2000 онтой харьцуулахад 111.3 сая ам.доллар буюу 31 хувиар, 2003 онтой харьцуулахад 56 сая ам.доллар буюу 15 хувиар тус тус өссөн байна. 2004 оны худалдааны нийт эргэлтийн 20.6 сая ам.доллар нь экспорт, 341.9 сая ам.доллар нь импортод ногдож байгаа нь тус улстай хийж байгаа манай худалдааны тэнцэл нь ихээхэн алдагдалтай байгааг харуулж байна.

Монгол-ОХУ-ын хоорондын худалдаа (сая ам.доллар)


Үзүүлэлт	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Экспорт	517.5	66.8	45.1	44.9	47.9	41.2	20.6
Импорт	716.2	202.0	206.2	225.9	237.6	265.4	341.9
Нийт бараа эргэлт	1233.7	268.8	251.3	270.8	256.6	306.6	362.6
Баланс	-198.7	-135.1	-161.0	-181.0	-189.6	-224.2	-321.0

Дээрх хүснэгтээс үзэхэд манай улсын худалдааны тэнцлийн алдагдал тогтмол өссөөр ирсэн бөгөөд сүүлийн 4 жилд Монголоос Орост гарч буй экспорт 2 дахин буурч, харин Оросоос Монголд экспортолж буй бүтээгдэхүүн 1.6 дахин өссөн байна. Орост ногдож байгаа экспорт нь Монгол Улсын нийт экспортын 2.4%-ийг эзэлж байгаа нь худалдааны хамгийн ойрын түнш болох орон гэхэд маш чамлалттай байна. 2004 оны ОХУ-ын импортын эрс өсөлт нь манай гол импортын бүтээгдэхүүн болох нефтийн бүтээгдэхүүн, түүн дотор бензин, дизель түлшний үнэ дэлхийн зах зээл дээр эрс өссөнөөс ихээхэн шалтгаалсан. Оросын Холбооны Улсаас Монгол руу импортолж байгаа бүтээгдэхүүний 50 гаруй хувийг зөвхөн газрын тосны бүтээгдэхүүн эзэлдэг ба өнгөрсөн хугацаанд газрын тосны бүтээгдэхүүний үнэ 42 хувиар өссөн нь импорт ихээр өсөж балансын алдагдал нэмэгдэхэд нөлөөлжээ. Харин манай экспортын гол бүтээгдэхүүн болох үхрийн маханд ОХУ-ын Мал эмнэлгийн байгууллагаас Монголд малын гоц халдварт өвчин гарсан гэдэг үндэслэлээр хориг тавьсны улмаас манай экспорт ихээхэн багасахад нөлөөлсөн.

Экспортын бүтэц, орноор, 2004 он



Импортын бүтэц орноор, 2004 он



2. ОХУ-ын ДХБ-д элсэн орох ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд

ОХУ Дэлхийн Худалдааны Байгууллагад нэгдэн орох хэлэлцээг 1995 оноос эхэлсэн бөгөөд энэ хугацаанд тус байгууллагын 58 гишүүн улстай тарифын асуудлаар, 30 улстай үйлчилгээний худалдааны асуудлаар тус тус хэлэлцээрүүдийг явуулж байна.

Монгол Улс ОХУ-тай ДХБ-ын хүрээнд 1999 оноос барааны тарифын болон тарифын бус хяналт, саад тотгор, хязгаарлалтыг бууруулах, 2 орны худалдааг хөнгөвчлөх, чөлөөтэй болгох асуудлуудаар албан ёсны хэлэлцээрүүдийг хийж ирсэн.

2005 оны 4 дүгээр сард Монгол-Оросын хоёр талын ээлжит хэлэлцээ Женев хотноо 8 дахь удаагаа болж тариф ба тарифын бус асуудлуудыг үргэлжлүүлэн хэлэлцсэн байна. ОХУ 600 орчим нэрийн бараа бүтээгдэхүүнд тарифын санал ирүүлснээс Оросын зах зээлд нийлүүлэгдэж болох манай 100 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд түлхүү анхааран хэлэлцээ хийгджээ. ОХУ-ын анхны санал нь одоогийн мөрдөгдөж байгаа барааны дундаж тарифаас 50%, үүний дотор ХАА-н гаралтай барааны тариф нь 100% өндөр байжээ. 1999 онд ОХУ-аас анхны санал авснаас хойш хоёр тал олон удаа хэлэлцээ хийсний үр дүнд нийт барааны дундаж тариф 13 хувь, үүнээс ХАА-н барааны дундаж тариф 12% байхаар тохирсон болно. Мөн тохиролцоот тарифт хүрэх шилжилтийн хугацааг дунджаар 2.2 жил байхаар тохиролцжээ.

ОХУ Дэлхийн Худалдааны Байгууллагад орсны дараа импортын дундаж тарифыг өөрчлөх болно гэдгийг мэдэгдсэн. Үүнд: ДХБ-д орсны дараах шилжилтийн үед импортын дундаж татварыг 7.5-т хүргэх юм. Гэхдээ энэ үзүүлэлт нь аж үйлдвэрийн болон ХАА-н бүтээгдэхүүнд өөр өөр байх болно. Аж үйлдвэрийн бараанд 5% байх бол ХАА-н бүтээгдэхүүнд өөрчлөлт орохгүй байхаар байна. ОХУ өөрийн экспортын бараанд ногдуулах татварыг аажмаар бууруулж, улмаар ДХБ-д нэгдэн орсноос хойш 4 жилийн дотор экспортын татварыг тэглэхээ амлажээ. Гэхдээ газрын тосны, түлш-эрчим хүчний бүтээгдэхүүнүүд болон хар, өнгөт металлын хаягдал гэх мэт чухал түүхий эдийн экспортын татварыг хэвээр байлгахаар байна.

Өнөөдрийн байдлаар ОХУ нь Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэн орох нөхцөлөө бүрдүүлэх зорилгоор импортын тарифаа аажмаар бууруулах бодлогыг баримталж байгаа боловч импортын дундаж тариф 1-1.5 % нэгжээр нэмэгдсэн байна. Учир нь сүүлийн жилүүдэд мах, элсэн чихэрийг их хэмжээгээр импортолсон тул энэ бүтээгдэхүүнүүдийн импортын тариф өндөр хэвээр байна. Өндөр тарифтай импортын бүтээгдэхүүний импортын хэмжээ өссөнөөс шалтгаалан татварын ерөнхий дундаж үзүүлэлт өндөр харагдаж байгаа юм.

ОХУ, ДХБ-ын худалдааны олон талтай хэлэлцээрүүдийн даган мөрдөх үүргийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ нэгдэн орох тухай протоколын дагуу үндэсний эдийн засаг, эрх зүйн тогтолцооны зохицуулалтыг ДХБ-ын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд чиглэсэн үүргүүдийг авсан.

Үүний зэрэгцээ Оросын тал ДХБ-д нэгдэн орсон үеэс эхлэн эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын стандарт, журам дүрмийг мөрдөх, 1994 оны Худалдааны Тарифын Ерөнхий Хэлэлцээрт чөлөөтэй дамжин өнгөрөх тухай 5-р заалтыг хэрэгжүүлэх зэрэг амлалтуудыг авч байна.

Системийн асуудлаарх хэлэлцээний явцад ДХБ-ын гишүүн орнууд дараах шаардлагуудыг Оросын талд тавьж, үүрэг амлалт авахыг шахаж байгаа болно. Үүнд:

- Маханд тогтоосон квотын хуваарилалт ойлгомж муутай
- Хэрэгжилт хүндрэлтэй
- Импортын бараанд тарифын бус олон шаардлага тавьдаг
- Ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлаар хэтэрхий хатуу нөхцөл баримталдаг
- Аж үйлдвэрийн салбарын татаас өндөр байна гэж ажлын хэсгийн гишүүн орнууд үзэж байгаа ба ДХБ-ын “стандартын” заалтуудыг ОХУ нь гишүүн болсон цагаас эхэлж мөрдөх шаардлагыг тавьж, зохих үүрэг, амлалтуудыг авахаар хэлэлцээ хийж байна.

ОХУ болон Монгол Улс нь ОХУ-ыг ДХБ-д нэгдэн орохтой холбогдсон 2 талын хэлэлцээрийг 2005 оны 10-р сарын 5-нд дуусгаж, албан ёсны тэмдэглэлд гарын үсэг зуржээ. Үүнд ОХУ-ын талаас Эдийн засаг, худалдааны сайд Оскарович Греф, Монголын талаас Үйлдвэр, худалдааны сайд Сүхбаатарын Батболд нар гарын үсэг зурсан байна.

МОНГОЛЫН ЭКСПОРТЛОГЧ КОМПАНИУДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД

Монгол-Оросын худалдаан дахь тарифын бус саад тотгор, шаардлагын талаарх судалгааны дүгнэлтэд дараах байгууллага, хүмүүстэй ярилцлага хийсэн болно. Үүнд:

- ОХУ-тай худалдаа хийдэг Монголын бизнес эрхлэгчид
- ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны ажилтнууд
- ОХУ-ын Мал эмнэлгийн алба
- ОХУ-ын Хил, гаалийн албадууд
- Буриадын Өөртөө засах орон болон Эрхүү мужийн захиргааны ажилтнууд.

Дараах асуудлуудыг судалсан болно. Үүнд:

- Худалдаан дахь тарифын бус саад тотгор, хязгаарлалтууд
- Тэдгээр тарифын бус саад тотгор, хязгаарлалтуудыг даван туулах арга зам
- Худалдааны хэмжээг цаашдаа сайжруулах арга зам
- Худалдааны тэнцлийн алдагдлыг багасгах хүчин зүйлс

1990 онд хоёр улсын улс төр, эдийн засгийн тогтолцоонд томоохон өөрчлөлт орсон. Монгол-Оросын гадаад худалдаа 90-ээд он хүртэл социалист орнуудын хүрээнд шилжих рублиэр явагдаж байгаад 1990-ээд оноос 2 улсын улс төр, эдийн засгийн бүтэц өөрчлөгдсөнөөс шалтгаалан Олон улсын хэм хэмжээнд тохируулан хөрвөх валютаар худалдаа хийгдэх болсон. Хоёр улсад шинээр хувийн хэвшлүүд үүсэн хөгжиж, ихэнх худалдаа хувийн хэвшлийн болон хувьцаат компаниудын хооронд явагдаж эхэлсэн. Энэ үеэс 2 талын худалдаа шинэ шатанд гарч, эерэг, сөрөг үзэгдлүүд ихээхэн гарч ирсэн. Үүнд:

- 2 улсын хооронд худалдаа хийхэд худалдааны төлбөрийн тооцоо шууд бус гуравдагч орны банкаар дамжигдан хийгдэх болсон
- ОХУ дотоод зах зээлээ хамгаалах зорилгоор
 - Импортын тарифаа өндөр тогтоосон
 - Квот тогтоосон
 - Мал эмнэлгийн шаардлага өндөрсөн
- 2 улсын тухайн байгууллагуудын хооронд хэлэлцээр, зөвшилцлүүд шинээр сайн хийгдээгүй байсны улмаас 2 улсын хоорондын худалдаанд худалдааны вакуум (орон зай) үүссэн.

Монголын худалдааны гол түншүүдийн харилцаа тогтоох, шийдвэр гаргах хязгаарлагдмал хүчин чадлын хүрээнд худалдааны сул харилцаа тогтсон байна. Эдгээр түншүүдэд Сибирь, Тува, Буриадын Өөртөө засах орнууд хамаарна. Худалдааны асуудалд Москвагаар зөвшөөрөгдсөн байх олон тооны зөвшөөрөл, лиценз саад болж байна.

1. Махны экспортод квот тогтоох

Монгол малын бүтээгдэхүүн нь Монголоос ОХУ руу гаргах экспортын хэмжээг өсгөх гол эх үүсвэр ба төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед 60 гаруй мянган тонн мах экспортолж байсан. Монголын махны импортод түшиглэн Улаан-Үүд, Буриад, Эрхүү зэрэг хил орчмын хотуудад мах боловсруулах 6 том үйлдвэрүүдийг байгуулсан байна. Монгол Улсын мах боловсруулах 14 үйлдвэрүүд нь ОХУ-д мах экспортлох зөвшөөрөлтэй байгаа ба эдгээр үйлдвэрүүд нь жилд 50-60 мянган тонн мах боловсруулах хүчин чадалтай.

Урд жилүүдэд Монголын ихэнх махны экспорт "Бурятмяспром" оногдож байсан нь энэ үйлдвэр монголд ноогдсон махны ихэнх квотыг дангаараа ноёрхон эзэмшиж, өөрийн нөхцөлийг Монголын компаниудад тавьж, махны үнийг дэлхийн түвшнээс доогуур барьж байсан юм. Монголоос мах авах сонирхолтой лицензтэй бусад компаниуд нь өөрийн квотыг биржийн дуудлага худалдаан дээрээс (ОХУ 2005 онд 430 мянган тонн үхрийн мах импортлох квот тогтоосны 15% буюу 64.0 мянган тонныг биржээр дамжуулан зарсан) өндөр үнээр авч байгаа нь мөн л манай үнэнд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсаас 2005 онд 4-5 компани мах импортлох квотын зөвшөөрлийг авсан байна. Үүний 3 нь Буриадын буюу:

1. Бурмяспром - **2000** тонныг квотоор, **3000** тонныг дуудлага худалдаанаас
2. Иволгийн мах үйлдвэр - **500** тонныг дуудлага худалдаанаас
3. СибмитХК - **500** тонныг дуудлага худалдаанаас

Үүнээс гадна:

4. Читийн махны үйлдвэр - **1000** тонн,
5. Эрхүүгийн махны үйлдвэр - **2500** тонн,
6. Тувагийн махны үйлдвэр - **3000** тн квотын зөвшөөрлийг авсан байна.

Үүнээс харахад Монголоос 10-15 орчим мянган тонн үхрийн мах энэ жил квотын хэмжээнд экспортлох боломжтой байгаа юм.

Энэ онд ОХУ-ын Засгийн газрын 878 дугаар тогтоолоор 2005 онд импортын үхрийн маханд олгосон квотын хуваарилалт:

1. Европын Холбооны улсуудаас **339.7** мянган тонн
2. АНУ **17.7** мянган тонн
3. Парагвай **3** мянган тонн
4. Бусад орнууд **69.6** мянган тонн мах

Үүнээс үзэхэд Монголд ноогдож байгаа квот нь нийт квотын 2% байгаа ч "Бусад орнууд" ангиллын 14 орчим хувь нь болж байна. Гэсэн хэдий ч Монголд ноогдож байгаа энэ квот нь Сибирийн тойргийн 12 субъектийн махны нийт хэрэглээний 0.01% байгаа юм. Энэ квотоос давсан хэмжээний махны импортод 60%-ийн импортын татвар ногдуулж байгаа нь нилээд өндөр байгаа юм. ОХУ-ын квот буюу Оросын гаалийн хилээр орох бараанд тоон хязгаарлалтыг дараах 3 тохиолдолд хэрэглэж байна.

Тарифын	Тарифын бус	Эдийн засгийн бус шинж чанартай
Барааны хэмжээнд хязгаарлалт тогтоохдоо энгийн гаалийн татварыг хэрэглэх.	(Эдийн засгийн шинж чанар агуулсан) Барааны хэмжээнд тоон хязгаарлалт тогтоож, түүнээс дээш барааг оруулахгүй байх.	Хилээр зорчиж буй хувь хүмүүсийн бараанд хязгаарлалт тогтоох.

2. Махны экспортод тогтоох нутаг дэвсгэрийн хязгаарлалт



Монголын махыг зөвхөн Урал хүртэлх субъектүүдэд импортлохыг ОХУ зөвшөөрдөг. Ингэснээр Монголын махыг одоохондоо худалдан авагч 2-3 субъект байдаг бөгөөд энэ нь үнийн чөлөөт өрсөлдөөнийг үүсгэдэггүй, харин ч Монголын компаниудыг хооронд нь өрсөлдүүлэн үнийг бага байлгах боломжийг бүрдүүлдэг.

Энэхүү ялгавартай хандах тогтолцооны асуудал нь Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээр/ДХБ болон бусад олон улсын байгууллагуудын олон улсын эрх зүйн хүрээнд хөндөгдөөгүй бөгөөд энэхүү асуудлыг цаашид шийдвэрлэх шаардлагатай байна.

3. Мал эмнэлгийн болон эрүүл ахуйн хяналт

ОХУ-ын Мал эмнэлэг, хорио цээрийн албанаас импортын маханд горим тогтоосон нь хэтэрхий хатуу нөхцөлтэй байна. Мал эмнэлгийн лицензийн зөвшөөрлийг Москвагаас төвлөрүүлэн өгдөг байдал нь олон шат дамжлагыг үүсгэснээр импортлогч компаниудад дарамт болж байна.

Оросын мал эмнэлгийн байгууллагаас гаргасан дүрмээр уг мах нь эпизотын болон гельминтологын өвчлөлтөд өртөх магадлалаас хамааран худалдан авч байгаа махыг 4 ангилалд багтаадаг байна. Үүнд:

“А” ангилал - Эдгээр махыг зөвхөн нөөш бэлтгэх зориулалтаар 2-оос доошгүй цаг, 80 хэмд боловсруулна.

“В” ангилал - Эдгээр махыг 75 хэмд боловсруулалт хийнэ.

“С” ангилал - Эдгээр махыг хيام болон чанаж утах технологийн горимын дагуу зохих хэмд боловсруулсан бүтээгдэхүүн болгох.

“Д” ангилал - Хязгаарлалтгүй чөлөөтэй худалдаалах.

Монголын мал нядалгаа 9-10 сард явагддаг үеэр Оросын мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүд ирж мах комбинатууд дээр бэлтгэл ажлыг хянан өөрсдийн тамга тэмдгийг нойтон махан дээр тавьж байгаа билээ. Гэтэл 11, 12 сард лицензээ авсан субъект нь нойтон махан дээрээ тамга тэмдэг тавиулах боломжгүй болж байгаа юм.

Үүнээс гадна, Монголын махыг “С” зэрэглэлд багтаан зөвхөн хيام, халуун боловсруулалт хийж борлуулах ангилалд багтаасан нь Монголоос хонь, ямааны мах авах боломжийг багасгаж байна.

Манай улсын газар нутаг том, бэлчээрийн мал аж ахуй зонхилж байгаа нь малын халдварт өвчин гарсан тохиолдолд тус нутагт хорио цээрийг тогтоож тусгаарлах боломжтой. Энэ тохиолдолд Монголын өөр бүс, нутаг, аймгаас эрүүл мах экспортлох

боломжтой ч Оросын мал эмнэлгийн байгууллага нь улсын хэмжээнд хориг тавьж байгаа нь манай 2 орны худалдаанд асар их саад болж байна.

Махны экспортлогчдод гардаг бас нэг бэрхшээл бол импортлогчдын хүсэлтээр дараа төлбөрийн хэлбэрээр махаа экспортолдог нь төлбөр хугацаандаа төлөгдөхгүй байх, улмаар 2-3 жил сунжрах, зарим нь өдийг хүртэл төлбөрөө авч чадахгүй байгаа нь бизнес эрсдэлгүй үргэлжлүүлэх боломжийг алдахад хүрч байна.

Арай жижиг экспортлогч/импортлогч компаниуд нь арилжааны хэлбэрээр махыг гурил, түлш, цай болон бусад бараагаар сольдог байна. Оросын тал эхэндээ бараагаа цаг тухайд нь нийлүүлж байснаа сүүлдээ чанар хангахгүй барааг нийлүүлэх болсон байна. Ийм залилангийн шинжтэй үйлдэл нь Оросын талд стандартчилагдсан хяналт шаардагдаж байгааг харуулж байна. Завханы махны үйлдвэр ийм арилжаа хийж байгаад 2 сая төгрөгийн алдагдалд ороод байна. Монголын талын субъект гэрээний дагуу мөнгөө нэхэмжлэн хөөцөлдсөн боловч Оросын алслагдсан хуулийн байгууллага, засаг захиргаа нь хэтэрхий их авилгалд идэгдсэн тул ямар ч амжилтанд хүрээгүй байна.

Монголын Мах Импекс ХХК нь Буриадын зах зээлд Монголын махны хэрэгцээ их байгааг харгалзан Оросын зах зээлд шууд гаргах зорилгоор Буриадын Иволги хотод Монголоос анхны хөрөнгө оруулалттай (230 мянган ам.доллар) мах боловсруулах үйлдвэрийг 2003 оны 12-р сард ашиглалтад оруулсан байна. Үйлдвэрлэлээ эрчимтэй явуулж эхэлсэн боловч гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого сул, олон хяналт шалгалттай, мөн Монголоос авах түүхий эд болох маханд квотын болон мал эмнэлгийн байгууллагаас зөвшөөрлийг зохих хэмжээнд олгоогүй зэргээс шалтгаалан үйлдвэрлэлээ хэвийн явуулах боломжгүй болж, алдагдалтай ажиллаж, эцэст нь ашиггүй нөхцөлтэйгөөр худалдах болжээ.

Монголтой хил залгадаг нутгуудад махны хангамж нь хэрэгцээт хэмжээнээс маш доогуур, үүний зэрэгцээ махны жижиглэнгийн үнэ 1 кг нь 4-5.5 ам.доллартай тэнцэхээр, зарим алслагдсан нутгаар 7 ам.доллар орчим байгаа нь тус нутагт махны хэрэгцээ маш их байгааг харуулж байна. Дээрх байдлаас шалтгаалан Увс, Завхан, Ховдын хил орчмын нутгаас хил давуулан малын хулгай хийх асуудал ч байнга гарч байна.

4. Стандартын шаардлага

Монголын ихэнх үйлдвэрүүд Оросын техник технологиор баригдан Оросын стандартыг мөрдлөг болгодог байсан. Экспорт, импортын бүтээгдэхүүний чанарыг үнэлэх талаар Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, ОХУ-ын Стандартчилал, чанарын баталгаажуулалтын улсын хорооны хооронд хамтран ажиллах хэлэлцээрийг 1996 онд хийсэн. Гэвч сүүлийн 10 жилд Оросын стандартад ихээхэн өөрчлөлтүүд орч түүний талаарх мэдээлэл ирдэггүй бөгөөд Оросын стандартын байгууллагын бүтэц өөрчлөгдөж эдгээр мэдээлэл, материалууд нь төлбөртэй болсноор эдгээр 2 байгууллагын уялдаа, холбоо багассан байна. Монгол Улсаас ОХУ руу экспортолж буй бүх бараанд тавих стандартын шаардлага нь маш хатуу байдаг байна (хивс, савхи, ноолуур, үслэг эдлэл).

Монгол Улс ДХБ-ын гишүүн болсон болон ОХУ тус байгууллагад гишүүнээр элсэхтэй холбогдон хоёр орны дээрх стандартын байгууллагуудын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах талаар харилцан тохиролцоонд хүрээд байна.

Монгол-Солонгосын хамтарсан Кроун ХХК нь өөрийн бүтээгдэхүүн болох автомашины түлшний шүүлтүүрийг ОХУ-д экспортлохын тулд Оросын стандарт, хяналтын албаны 2 хүнийг өөрсдийн зардлаар Солонгос улсад үйлдвэр дээр нь аваачиж техник, технологитой нь танилцуулснаар зөвшөөрлөө авахаар болсон байна.

МОНГОЛЫН ИМПОРТЛОГЧ КОМПАНИУДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД

ОХУ-аас Монголд импортолж буй импортын хэмжээ Монголын импортын 33.5 хувийг эзэлж байгаа ба гол импортын бүтээгдэхүүн нь нефтийн бүтээгдэхүүн юм.

Манай улсын 10-аад компани ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортоор авч байгаа ба импортын ихэнх хувийг ЮКОС компаниас, тухайлбал энэ компанийн Ангарск дахь нефть боловсруулах үйлдвэрээс авч байна. ЮКОС компанийн охин компани болох Юмтрейд компани нь Монголд үйл ажиллагаагаа явуулах болсноор нефтийн импортод урьд нь гардаг байсан бэрхшээлүүд үндсэндээ үгүй болсон байна.

Нефтийн импортын гол хүндрэлтэй асуудал бол тээврийн өндөр өртөг, Оросын экспортын гаалийн татварууд юм. Нефтийн импортын бүтээгдэхүүнд чанар, тоо хэмжээнд тавих хяналтыг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Хяналтын лаборатори явуулдаг байсан бол ЮКОС компани Орост тус компанид хяналт явуулдаг Сейболт компаниар энэхүү хяналтыг явуулах шаардлага тавьсны үндсэн дээр энэ компаниар хөндлөнгийн хяналт шалгалтыг хийлгэх болсон байна.

Монгол-Оросын худалдааг либералчилах ажлын хэсгийн 5-р хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний тээврийн тарифт хөнгөлөлт үзүүлэх асуудлаар тодорхой хэлэлцсэний үр дүнд ОХУ-ын Тээврийн яам болон Тарифын бодлогын холбооны албанд тодорхой нэрийн бараанд хөнгөлөлт авах талаар албан ёсны хүсэлтийг тавьснаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж Оросын Төмөр замын байгууллагын төлөөлөгч мэдэгдсэн байна.

ОХУ-аас ихээхэн хэмжээний хүнсний бүтээгдэхүүнийг Монголын хүнсний худалдааны голлох компаниуд импортоор оруулж ирж байна. Оросын компаниудаас бараа худалдан авахад гардаг гол хүндрэл бол бараа бүтээгдэхүүний төлбөрийг заавал 100% урьдчилан төлүүлдэг явдал юм. Хэдийгээр зарим нэг компани 10 гаруй жил Оросын компанитай түншлэн ажиллаж байгаа боловч заавал дээрх шаардлагыг тавьдаг байна. Үүнийг тайлбарлахдаа гадаад худалдааны эрх лиценз олгогч дээд байгууллага болон гааль, хяналтынх нь ийм шаардлагыг тавьдаг гэжээ. 100% төлбөрөө хийчхээд байхад 2-3 сар хүлээж бараагаа авах ч тохиолдол их байна. Оросын байгууллагуудын үйлчилгээний хөлс өндөр, Монголоос орж ирсэн ам.доллар нь харилцагч компанийн дансанд ортлоо их уддаг байна. Харилцагч тал орж ирсэн мөнгийг банкнаас рубль болгон авдаг бөгөөд орж ирсэн ам.долларыг рубль болгон шилжүүлэхдээ ашигтай ханшийг хүлээж байна гэж шалтаглан хугацаа удаах тохиолдол ч гарч байсан байна. Барааны төлбөр ямар нэг шалтгаанаар 5-10 ам.доллараар дутуу төлөгдсөнөөс болж Оросын гааль, төмөр зам төлбөрийг дутуу гэж шалтаглан ачилтыг хойшлуулан вагоны сул зогсолтын торгуулийг төлөх тохиолдлууд ч бас байдаг байна. Бараа ачилтын үед бараа алдагдах, дутах асуудал их болсон.

Оросын бараа, бараа тээвэрлэлтийн чанар сүүлийн үед ихээр доголдох болсон. Үүнд:

- Мечта плитканүүд дэлбэрч шатсан тохиолдол.
- Бараа тээвэрлэлтийн үед гэмтэл их гарах. Эдгээр тохиолдолд Оросын харилцагч талд гомдол тавьдаг ч хүлээн авдаггүй, нөхөн төлбөр ч олгодоггүй.
- Хоёр орны худалдаа хийхэд Оросын төмөр замын гадаад тээврийн тариф 2.5 дахин үнэтэй байдаг.
- Вагон захиалга, хуваарилалт хэтэрхий төвлөрсөн.
- Оросоос Монгол хүртэлх тээвэрлэлтийн хугацаа удаан байдаг нь худалдаанд хүндрэл учруулж байна.

Оростой хийх гадаад худалдаанд саад болж байгаа бас нэг бэрхшээл бол Орос дахь хээл хахууль, авилгал, гэмт хэрэг юм. Үүнд сүүлийн жилүүдэд гаалийн ажилтануудтай холбоотой 20 млрд ам.долларын 100 мянган хэрэг бүртгэгджээ. Ер нь Оросын Гаалийн өндөр тарифтай хууль нь дотоодынхоо үйлдвэрлэгчдийг хамгаалахаасаа илүү авилгал үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн хууль гэж хүмүүс үздэг байна.

- Манай хил дээрх барааны эргэлт бага ч жижиг хахуулийг манай ганзагачид байнга өгдөг гэж дээрх нэвтрүүлэгт оролцсон хүмүүсээс хэлж байлаа.
- Монгол иргэдийн автомашиныг хулгайлан мөнгө нэхэн буцааж өгөх асуудал сүүлийн үед гарах болсон.
- Оросын хотуудын зах дээр худалдаа хийж байгаа Монгол иргэдээс татвар авдаг рекэтүүд ч байсаар байна.
- Орост худалдаа, бизнесийн үйл ажиллагаа явуулахад олон бичиг баримт бүрдүүлэн зөвшөөрөл авах асуудал гардаг.
- Хил дамжих урсдаг голын урсгалын боож өөрсдийн бизнесийн хэрэгцээнд ашигладаг.

АЛТАНБУЛАГ, СЭЛЭНГИЙН ГАНЗАГЫН НАЙМААЧДАД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД

Манай хоёр улсын хооронд авто тээврээр явагдаж байгаа зохих худалдааны нилээд хэсэг нь Алтанбулаг-Хиагтын үндсэн боомтоор явагдаж байна.

Энэ боомтын Монголын урд талын авто тээврийн боомт Замын-Үүд, Эрээн, Оросын бусад боомтуудтай (Забайкальск-Манжуур, Алс Дорнод) харьцуулахад ачаалал маш бага ч машин нэвтрэн өнгөрүүлэх, хил гаалийн бүрдүүлэлт хийх ажиллагааны хугацаа маш удаан, хүнд суртал ихтэй байна.

Хэдийгээр энэ хилийн 2 талын боомтыг хөрөнгө зарж, хүчин чадлыг нь нэмэж, өдөрт 500 авто машин өнгөрөх хүчин чадалтай болгосон гэх боловч зөвхөн жижиг машин л гэхэд нэг талдаа 5-15 машин, хоёр талдаа нийт 20-40 машин гарч байна. Монголын талаас Орос руу гарах явцад жижиг машин Монголын хил гаалийн постон дээр 3-15 минут л зарцуулж байхад Оросын хил гаалийн постон дээр 15 минутаас 2 цаг хүртэл зогсож байна. Гаалийн шалгалт хийх дундаж хугацаа 30 минут/1 машин байдаг байна.

Хэрэв энэ хугацаанаас шалгалтыг хурдан явуулж, олон машин гаргавал тус байцаагч нь ажлаа чанаргүй хийсэн гэсэн үнэлэлтийг авч болох тул тэдэнд яарах шаардлага байдаггүй байна. Тэгээд ч гаалийн давхар хяналтаас гадна тагнуулын албаны хүмүүсийн хяналт их байдаг. Монголын талаас машинаар гарахын тулд 2-3 хоног хүлээх тохиолдол ч гардаг байна. Оросын гааль дээр мэдүүлэх бараа, мөнгө байхгүй ч гэсэн заавал гаалийн бүрдүүлэлтийг 2% үйлдэж 1-ийг нь байцаагчид, 1-ийг нь өөртөө авч үлдэх ёстой.

Монгол-Оросын хилийн боомт орчимд амьдардаг хүмүүс жижиг худалдаа эрхлэн аж амьдралаа залгуулдаг байна. Одоогийн байдлаар Алтанбулаг Сэлэнгийн 300 орчим иргэд, Хиагтын 50-100 орчим орос иргэд жижиг худалдаа эрхлэн Монголоос өргөн хэрэглээний бараа, хувцас, Оросоос хоол хүнсний зүйлс зөөж байна. Эдгээр жижиг ганзагын наймаачид нь Улаан-Үүд, Эрхүүгийн наймаа хийдэг хүмүүсийн барааг жижиглэн зөөж гаргадаг ба энэ барааны өртөг нь 20-иос 100 ам.доллар хүртэлх хэмжээний үнэтэй байгаа боловч гаалийн зүгээс маш хатуу шаардлагыг тавин ялгаварлан гадуурхах бодлогыг явуулж байна. Үүнд:

- Хиагт орчмын Орос иргэд хилээр гарахдаа 1 хүн 50 кг барааг (ижил нэр төрлийн бус) сард гурван удаа гаалийн татваргүйгээр авч гарах эрхтэй байна.
- Хувь хүн нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах зорилгогүйгээр долоо хоногт 1 удаа хилээр зорчих тохиолдолд 65 мянган рубль (2,320 ам.доллар) хүртэлх барааг 50 кг жингийн хязгаарлалттай гаалийн татваргүйгээр авч гарах эрхтэй.
- Энэ нь Монгол иргэдэд үйлчилдэггүй.

Хил орчмын хүмүүсийн авч гарч байгаа барааны үнэлгээ болон татвар нь өндөр байгаа нь жижиг наймаа хийж буй хүмүүсийн хувьд хүндрэл учруулж байна. Үүнд:

- Үнэлгээ хийх боломжгүй барааны 1 кг бүрт 4 еврогийн гаалийн татвар ногдуулж байгаа нь өндөр байна. Иймээс тэд бараагаа авч гарахын тулд хахууль өгөх, нуун далдлах асуудал ихээр байнга гарч байна.

- Иргэд биедээ байгаа буюу гар цүнхэндээ байгаа бараануудаа гаалийн мэдүүлэгт бичээгүй гэсэн үндэслэлээр байнга бараагаа хураалгаж байдаг байна. Үүнд:
 - 4 ширхэг жинсэн өмд машины суудал дор тавьснаас 2004 оны 7-р сараас энэ хүртэлх хугацаанд Оросын гааль дээр машиндаа бараа нууж гаргах гэсэн шалтгаанаар 6 машин хураагдаад байгаа асуудал байна.
 - Гар цүнхэнд байгаа бараануудыг гаалийн мэдүүлэгт бичээгүй гэсэн үндэслэлээр байнга бараагаа хураалгаж байдаг байна.
 - Дөрвөөс таван удаа явсны дараа заавал нэг бараагаа хураалгадаг гэж байна.

Энэ хилийн боомтоор ганзага маягаар эргэлдэж буй нийт барааны дүн сардаа 50,000 ам.долларт хүрэхгүй. Энэ нь эдүгээ ОХУ-ын өргөн хэрэглээний барааны 40%-ийг, Буриадын 100%-ийг ганзагын наймаачид гэх хувь хүмүүс импортоор оруулж ирж байгаа үзүүлэлттэй харьцуулахад маш өчүүхэн тоо юм.

Оросын хил орчмын нутгийн хүмүүсийн амьжиргаа тийм ч өндөр биш, худалдан авах чадвар сул дорой байгаа нь Монголоос эдгээр ганзагын наймаачдын хямд өртөгтэй, хамгийн хямд зардлаар орж ирсэн Хятад, Солонгос, Гонконг, Монголын өргөн хэрэглээний бараанууд тэдний хэрэгцээг тун сайн хангаснаар эрэлт хэрэгцээтэй байна. Ер нь Сибирийн өргөн хэрэглээний барааны ихэнх хувийг Хятад, Солонгосоос ганзагын наймаагаар оруулж ирж байгаа бөгөөд Оросууд Манжуур Борзын хилийн боомтуудаар оруулан ирч 2.3 мянган км тээвэрлэн, Сибирийн хотууд, цаашлаад Төв Оросын хотуудад хүргэж байгаа юм.

Хил орчмын болон Улаан-Үүд, Эрхүү хотуудад Монголоос оруулж ирсэн өргөн хэрэглээний барааг зах дээр зарж амьдардаг монголчууд 300-аад байна.

Улаан-Үүд хотын худалдаа эрхэлдэг Монгол иргэд нийлж аж ахуйн нэгж байгуулан татвар хураамжуудыг нь төлөн үйл ажиллагаагаа явуулахаар эхлэн ажиллаж байна. Ийм аж ахуйн нэгж байгуулан ажиллах зөвшөөрлийг авахад л 8 байгууллагаас зөвшөөрөл авч байна. Жишээ нь: Оросын Холбооны Улсад жижиг худалдаа эрхлэх зөвшөөрөл авахад л наад зах нь доорх зөвшөөрлүүдийг Москва болон орон нутгаас авдаг. Үүнд:

1. Цагдаагийн байгууллага
2. Хөдөлмөрийн яамн
3. Гадаадад цагаачлагчдын алба
4. Улсын албан татварын газар
5. Хөдөлмөрийн нөхцөлийг хангах гэрээг авах
6. Нийгмийн хамгаалал, аюулгүй албаны яам
7. Эрүүл мэндийн яам
8. Үнэ, стандартын улсын хороо болно.

Эдгээр зөвшөөрлийг нэг дороос авах боломжгүйгээс маш их хугацааг зарцуулдаг бөгөөд эдгээр байгууллагууд нь янз бүрийн бичиг баримтуудыг шаарддаг байна.

Зөвхөн ажлын буюу гэрийнхээ утсанд утасны дугаар харах үйлчилгээг хийлгэхийн тулд сар хагас хөөцөлдөж, 2-3 газраас зөвшөөрөл авч байсан байна. Орос иргэдэд төдийлөн төвөг учруулахааргүй журам үйлчилдэг байна.

ТЭЭВЭРЛЭЛТ, ХУДАЛДААНД УЧИРЧ БУЙ СААД ТОТГОРУУД

Монгол Улс далайд гарцгүй улс тул Европын Холбооны улсуудтай хийх худалдаа ОХУ-аар дамжин өнгөрөх тээврээр дамжин хийгддэг. ОХУ нь ДХБ-д элссэн үеэсээ эхлэн ГАТТ-ын 5-р зүйлийн заалт болох дамжин өнгөрөх тээврийн Чөлөөтэй дамжин өнгөрөх тухай заалтыг хэрэгжүүлэх амлалтыг авч байна.

Манай зарим компаниуд болон хувь хүмүүс 1990-ээд оноос эхлэн Европын Холбооны орнуудаас суудлын автомашин болон бараа бүхий ачааны тэргийг ОХУ-аар дамжуулан хөлөөр нь оруулж ирдэг болсон. Гэвч 2000 оноос эхлэн ОХУ-ын нутгаар хөлөөрөө явж буй машиныг Оросын баруун хилээр орж ирэхэд 1,300 ам.доллар барьцаалан авч Хиагтын хилээр гарсан гэсэн Хиагтын гаалийн бичгийг үндэслэн барьцаат мөнгийг буцаан авах гэхэд үүнийг нь Хиагтын гааль олгохгүй заавал орж ирсэн хил дээрээсээ ав гэсэн шаардлагыг тавьдаг байна. Энэ 2 хил хоорондоо 6 мянган км орчим зайтай тул энэ мөнгийг авахад маш их зардал чирэгдэл гарах болсон. Дамижин өнгөрөхөөр явж байгаа автомашинуудыг Оросын Замын цагдаагийнхан байнга зогсоож мөнгө нэхдэг болон дээрх барьцааны мөнгөний улмаас сүүлийн 3-4 жилд дамжин өнгөрөхөөр Европын Холбооны улсаас хөлөөр нь импортлодог байсан автомашины импорт бараг бүрмөсөн зогссон гэж хэлж болно.

Манай төмөр замын байгууллагууд ОХУ-аар дамжуулан дамжин өнгөрөх тээврийг Бээжин-Улаанбаатар-Европын Холбооны улсууд Европын Холбооны улс-Улаанбаатар-Бээжин гэсэн чиглэлээр хийж байна. Өдгөө Европ-Азийг холбосон төмөр замын гол 3 суваг байна. Сүүлийн жилүүдэд манай төмөр замын тээвэр зуучийн компаниуд Хятад болон Монголоос Европын Холбооны улс хүртэл мөн эсрэгээр төмөр замын тээврийг маш хурдан шуурхай хийх болсноор ачаа эргэлт нэмэгдэх болсон юм. Хятад, Монголоос далайн тээврээр барааг Европын Холбооны улсуудад хүргэхэд 30-45 хоног болдог бол ОХУ-аас төмөр замын дамжин өнгөрөх тээврээр 10-21 хоногт хүргэх болсон. Гэсэн хэдий ч дараах шалтгаанаар усан тээврийг илүүд үзэх хандлага түгээмэл болоод байна. Үүнд:

- Оросын тал дэндүү хатуу гаалийн шалгалтыг хийдэг
- Бараа нь тээврийн хавсралт бичгээсээ зөрсөн гэж шалтаглан барааг хурааж авах
- Барааны бичиг баримтын бүрдүүлэлт бараатайгаа цуг ирдэггүй, хаягддаг.
- ОХУ-аар дамжин өнгөрөх онцгой татвартай бараанд (архи, тамхи г.м.) барьцаа тавиулж явуулдаг байгаа нь ихээхэн хүндрэлтэй байна.
- Оросоор дамжин өнгөрөх хугацаандаа лац, ломбо нь хөдөлсөн байвал барьцаат мөнгийг өгөхгүй гэдэг.
- Манай улс Европын Холбооны улс руу агаарын тээврээр ОХУ-аар дамжуулан худалдаа хийдэг ба ОХУ-ын Москва хотын Шереметьево олон улсын нисэх онгоцны буудлаар дамжин өнгөрөхдөө алдагдах, хулгайлагдах тохиолдлууд гардаг.


Хоёр улсын Засгийн газрын хоорондын комиссын “Худалдааг либералчилах ажлын хэсэг”-ийн удаа дараагийн хэлэлцээрийн үр дүнд дээрх барьцааг авахаа болино гэж байгаа нь худалдааг ихээхэн хөнгөвчлөх болно.

МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДАА: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


Өнөөдөр үйлчилж буй чөлөөт худалдааны журмын нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын худалдааны дийлэнх хэсэг нь ОХУ дээр тулгуурлах боломжгүй болсон байна. Гэсэн хэдий ч ОХУ-тай хийх худалдааны нөөц, боломж нь Монгол Улсын жижиг зах зээлд таатай нөлөөлөх нь тодорхой.

Монгол Улс нь ОХУ-тай худалдааны тэнцлийг хадгалахыг зорьж байгаа бөгөөд 2004 онд Монгол-Оросын худалдаа нь 362.6 сая ам.долларт хүрч, үүнээс 20.6 сая нь экспорт, харин 341.9 сая нь импортыг бүрдүүлээд байна. Монгол Улс цаашдаа ОХУ-аас оруулж ирэх импортын хэмжээг 340 сая ам.доллараас хэтрэхгүй байхаар төсөөлж байна.

Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өсөх хандлагатай байна. Хүрэх боломжгүй газраас бусад хэсэг дэх дэлхийн бүх нөөцийг нарийвчлан судалж тодорхойлсон байгаа билээ. Дэлхий дээрх тосны нөөц дуусах болоогүй ч газрын тосны үйлдвэрлэл дээд цэгтээ удахгүй хүрэхээр байна.



Ойрхи Дорнодын ОПЕК-ийн олборлогчдын эзэмшдэг дэлхийн газрын тосны зах зээл дэх хувьцаа 30%-аас хэтрэх тохиолдолд газрын тосны үнэ огцом өсдөг.



2000 оны 3-р сард болсон “Feasta” Бага хурал дээр Колин Кампбелл өөрийн “Мөнгө, эрчим хүч, дэвшил - дэлхийн газрын тосны үйлдвэрлэлийн гол гурван өндөрлөг” хэмээх илтгэлдээ:

“1970-аад оны эхэн үед ОПЕК-ийн олборлогчид дэлхийн зах зээлийн 30-аас илүү хувийг гартаа авах хүртэл бодит амьдрал онолын тооцоотой тун ойролцоо байсан. Харин энэ үеэс өөрийн эрх мэдлийг ашиглан ОПЕК газрын тосны үнийг хөөрөгдүүлж, эрэлтийг хязгаарласан. Газрын тосны өндөр үнэ эрэлтийг 2010 он хүртэл тогтоож чадна, харин 2010 оноос хойш газрын тосны нөөц дуусах учир үнээс хамаарахгүй болно”.

(<http://www.feasta.org/documents/feastareview/campbell.htm>)

ОХУ-аас Монгол Улсад оруулдаг импортын хэмжээний 50%-тай тэнцэх газрын тосны үнэ буурах магадлал тун бага юм. Хэмжээг ижил түвшинд тогтмол байлгах чадвар нь Оростой хийх худалдааны алдагдлыг багасгах боломжтой юм.

Монгол Улс 60,000 тонн мах экспортлох нөөц бололцоотой бөгөөд Монголын экспортын үнийн доод хэмжээ болох 1 кг үхрийн махыг 1 ам.доллараар үнэлбэл дараах тохиолдолд үхрийн махны нийт экспортоос 60 сая ам.доллар олох боломжтой.

- ОХУ руу экспортлох үхрийн маханд оногдуулах тарифын болон тарифын бус саад тотгор, хязгаарлалтуудыг багасгах
- Хүнд суртал, олон шат дамжлага бүхий мал эмнэлэг, эрүүл ахуйн хяналтыг багасгах
- Зах зээлийг Уралаас цааш өргөжүүлэх
- Европын Холбоон дахь зах зээлийг бий болгох
- Махан бүтээгдэхүүний экспортын нэр, төрлийг нэмэгдүүлэх (хонины мах, хурганы мах гэх зэрэг).

Сэлэнгэ, Алтанбулагийн орчмын нутгийн 300 орчим иргэд, Хиагтын 50-100 орчим иргэд жижиглэнгийн наймаа эрхэлдэг байна. Үүнд хил дамнасан наймааг чөлөөлбөл ганзагын наймаачдад өөрсдийн Оросын түншүүдтэйгээ наймаа хийснээр хил орчмын нутгийн амьжиргааны түвшинд эерэгээр нөлөөлөх болно.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсаас ОХУ руу экспортолж буй хамгийн гол бүтээгдэхүүний нэг бол мах, махан бүтээгдэхүүн бөгөөд цаашид ч Монголын гол экспорт байхаар байна. Монголоос экспортолж болох дээд боломжийг ашиглахын тулд тариф болон тарифын бус саад тотгоруудыг багасгах бүхий л арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй Үүнд:

- А.** Монголд ногдож байгаа үхрийн махны квотын хэмжээг ихэсгэх боломжийг хайх (“Бусад орон” ангиллаас). Монгол гэж нэр заалган квот тогтоолгох, квотыг 12-15 мянган тонноор тогтоолгож, жил бүр боломжоор нь нэмэгдүүлэх. Энэ тохиолдолд дуудлага худалдаагаас 1 тонн тутамд 80-120 ам.доллар нэмэгдэх зардал хасагдаж манай зах зээл тогтвортой байх боломжтой.
- Б.** Монголын мах экологийн цэвэр бүтээгдэхүүн, амт чанарын хувьд сайн. Оросын Сибирь орчмын хүмүүс Монголын махны чанарыг өндөр үнэлдэг зэргийг харгалзан Оросын мал эмнэлгийн байгууллагатай хамтран Монголын махыг эрүүлжүүлэх асуудалд хамтран ажиллаж Монголоос Орост экспортоор орж буй махыг “Д” зэрэглэлд багтаан оруулах талаар боломжтой арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. “Д” зэрэглэлд орсноор манай экспортын мах заавал боловсруулалт хийх шаардлагагүй, саад тотгоргүйгээр шууд худалдаалагдах боломжтой болох юм. Энэ тохиолдолд Монголоос мах худалдан авагчдын тоо ихсэж, Монголын махны эрэлт, хэрэгцээ нэмэгдэн махны үнэ 40-50 хувь өссөнөөр ОХУ-ын импортын махны үнийн төвшинд хүрэх боломжтой. Хонь, ямааны махыг ч экспортлох боломж нээгдэн махны нийт экспорт 2-3 дахин нэмэгдэх боломжтой. Монголын махны экспортын бүтцийг өөрчлөн сайжруулж, бусад хөгжилтэй орнууд болох Япон, Солонгос, Арабын орнуудад гаргаж буй махны тоо, толгойг улам нэмэгдүүлснээр өөр ямар улсад мах экспортолж болох гарцыг олж нээн илрүүлэх хэрэгтэй байна. Ялангуяа хонины махыг Арабын оронд гаргаж, байгаа тоо хэмжээг улам ихэсгэн ОХУ-ын мал эмнэлгийн байгууллагын “Монголын хонины мах өвчлөлтийн магадлал ихтэй” гэсэн ойлголтыг өөрчлөх хэрэгтэй.
- В.** Монголын махыг гулуузаар нь гаргахаас гадна хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн хэлбэрээр гаргах боломжтой. Бүтээгдэхүүний нэр, төрлийг олшруулах, чанарыг баталгаажуулахын тулд ОХУ ялангуяа Сибирьт зохиогдож буй хүнсний яармаг, худалдаан оролцуулж зохих гэрчилгээ, чанарын үнэлгээнүүдийг авах шаардлагатай.
- Г.** Монголын малын дайвар бүтээгдэхүүнүүдийн өөрийн өртөг хямд, үүн дээр импортын хөнгөлөлтийн 25%-ийг эдэлж байгааг харгалзан энэ төрлийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах нь чухал байна. Ийм бүтээгдэхүүн хийх жижиг шугамуудыг мах боловсруулах үйлдвэрүүдэд суурилуулах нь оновчтой юм.
- Д.** Монголын малын махны экспортыг (ялангуяа бог малын) нэмэгдүүлэх бусад арга замуудыг хайж Оросын талтай тохиролцох (үүнд, хоёр улсын Батлан хамгаалах яамны шугамаар тохиролцон Оросын арми, Сибирийн цэргийн тойргийг Монголын малын махаар хангах боломж, ОХУ-ын Ерөнхийлөгч Путины Оросын алслагдсан районуудыг хөгжүүлэх хөтөлбөрт оруулах гэх мэт асуудлуудыг тохиролцож болох юм).

- Е.** Манай хоёр орны худалдааг сайжруулах асуудлын чухал хэсэг нь хил орчмын худалдаа, хамтын ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх болон худалдааны чөлөөт бүс байх болно. Хил орчмын худалдааг улам өргөжүүлэх, "Алтанбулаг" чөлөөт бүсийг байгуулах асуудал нь 2 орны худалдаанд ихээхэн ахиц гарч энэ боомтоор хийгдэх худалдаа өөр түвшинд гарах нь гарцаагүй. Алтанбулаг чөлөөт бүсэд бараа бүтээгдэхүүний бөөний төв, агуулахуудыг бий болгож Хятад руу тойрон явж байгаа худалдааны урсгалын ихээхэн хэсэг Монголоор дайран өнгөрч болох талтай.
- Ё.** Монголын хил орчмын байгалийн баялгийг ашиглах төслүүдийг хамтран хэрэгжүүлэх. Үүнд, Асгатын мөнгөний орд, Тавтын Алтны орд Улаан овооны нүүрсний орд гэх мэт. Ялангуяа, Буриадын болон Чита, Алс Дорнодын нутаг нь хүйтэн өвөлтэй, нүүрсний нөөцгүй байдлыг харгалзан нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, энэ тал дээр хамтран ажиллах нь хамгийн ашигтай хувилбар байж болох юм.
- Ж.** Монгол Улс Европын Холбооноос олгож буй "GSP+" тарифын хөнгөлөлтийг эдлэх болсон. Мөн Монголтой Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах асуудлыг АНУ-ын Конгрессоор хэлэлцэж байгаа зэрэг нь Монголын худалдааны тааламжтай нөхцөлүүдийг бүрэн дүүрэн ашиглахын тулд хил орчмын Оросын түүхий эд дээр тулгуурлан хамтарсан үйлдвэрүүдийг бий болгох нь зүйтэй. Үүнд, Сибирь болон Монголын хил орчмын гол экспортын бүтээгдэхүүн болох модыг Монголд боловсруулж Европын Холбооны улсуудад гаргаж болно. Мөн хаягдал төмрийг Монголд оруулан Дарханы төмөрлөгийн үйлдвэрт боловсруулж дээрх орнуудад гаргаж болох юм.
- З.** Дамжин өнгөрөх тээврийн саад тотгорыг арилгаснаар Монголоор дамжин Европын Холбоо хүртэл хийгдэх төмөр замын тээвэр ихээр нэмэгдэж болно. Монголоор дайран Европ-Азийг холбосон төмөр зам нь төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын баталсан Олон улсын бусад сүлжээнүүдээс 500-800 км дөт: Манай 2 хилийн хооронд 30 цаг л зарцуулж байгаа нь маш их хугацааг хэмнэнэ гэсэн үг юм. Монголын Төмөр Зам жилдээ 20 сая тонн ачаа дамжуулан тээвэрлэх хүчин чадалтайгаас өнөөдөр 50 хувийг нь л ашиглаж байна. Түүнээс гадна дамжин өнгөрч байгаа ачаанд 30-60 хувийн хөнгөлөлт үзүүлж байна. Манай улс энэ мэт өөрсдөдөө байгаа боломж бололцоог аль болох бүрэн дүүрэн ашиглаж, учирч буй саад тотгорыг аль болох дээд түвшинд түргэн шуурхай шийдэж байх шаардлагатай байна. Цаашид дан ганц Төмөр замын тээвэр ч бус 2007 оноос Монголоор дайран өнгөрөх Алтанбулаг-Замын-Үүдийн засмал зам ашиглалтад орсноор авто тээврийн дамжин өнгөрөх, аялал жуулчлалыг эрс нэмэгдүүлэх бололцоотой зэргийг урьдчилан төлөвлөж 2 хөрштэйгөө тодорхой тохиролцоонд хүрэх шаардлагатай.
- И.** Манай улсын импортод нефтийн бүтээгдэхүүн болон эрчим хүч ихээхэн үүрэгтэй билээ. Манай ойрын хөрш Эрхүү муж нь хамгийн хямд эрчим хүчийг үйлдвэрлэж байгаа бөгөөд байгалийн хийн ордын асар их нөөцтэй байгаа нь манай улс эдгээр бүтээгдэхүүнүүдэд илүү анхаарах шаардлагатай байна. Улаанбаатарт өнөөдөр явж буй авто машины ердөө 1% нь л хийгээр явж байна. Энэ тоог цаашид 50-60 хувь хүргэж гэр хорооллуудыг хий, нүүрс хослуулан хэрэглэдэг болгох нь эдийн засгийн хувьд ч хотын байгаль, экологийн хувьд ч ашигтай байх болно. Хийгээр явдаг машин импортлохыг гаалийн татвараар дэмжиж өгч болох юм.
- Й.** Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзлэх салбар бол аялал жуулчлал байж болох юм. Сүүлийн жилүүдэд Байгаль нуур орчмын жуулчлал эрс өссөн ба ялангуяа Европоос Байгаль нуур дээр ирж байгаа жуулчид Байгаль нуурын дүү болох Хөвсгөл нуурыг үзэх сонирхолтой байдаг байна. Мөн Хөвсгөл нуурт

очиж загасчлах сонирхолтой Оросууд их байдаг байна. Эрхүү хотоос Оросын хуучин хил Монд хүртэл 300 км ба Хөвсгөл нуурын эрэг Ханх хүртэл 23 км юм. Ханх-Мондын хил Олон улсын хил биш байгаан улмаас гадаадын жуулчид энэ хилээр нэвтрэх боломж байхгүй байна. Энэ хил Олон улсын хил болсон тохиолдолд жуулчлал богино хугацаанд 2-3 дахин өсөх магадлалтайг Эрхүүгийн албаны хүмүүс ярьж байлаа.

- К.** Манай хоёр орны хоорондын мэдээлэл, харилцааны салбар зохих хэмжээнд байхгүйн улмаас мэдээлэл, бизнесийн орон зайг үүсгэж байна. Хоёр орны Худалдааны танхимууд, бизнес болон олон нийтийн байгууллагуудын хоорондын харилцааг улам сайжруулах, улмаар хил ойролцоох Улаан-Үүд, Эрхүү хотуудад Монголын Худалдааны төвүүдийг байгуулан үйл ажиллагааг түүгээр дамжуулан явуулах боломжтой болох юм.
- Л.** Монгол Улс ТУХН-ын гол улсууд болох ОХУ, Казахстан, Украин, Белорусийн байгуулсан Эдийн засгийн нэгдмэл бүсэд нэгдэн орох асуудлыг судалж үзэх хэрэгтэй. Энэ байгууллага нь тус орнууд нэгдсэн худалдаа, тарифын бодлоготой болох онцлогтой юм.

Хавсралт 1. Дэлхийн Худалдааны Байгууллага

ДХБ нь дэлхийн худалдааны дийлэнх хэсэгт хэрэгждэг олон талт гэрээ, хэм хэмжээ, зохицуулалтын нэгдлээс бүрдэнэ.

I. Бараа худалдааны талаарх үндсэн олон талт гэрээнүүд:

- Тариф, Худалдаа (1994)
- Хөдөө аж ахуй
- Эрүүл ахуйн арга хэмжээг хэрэглэх
- Сүлжмэл бүтээгдэхүүн, хувцас
- Худалдаанд учрах техникийн шинжтэй хүндрэлүүд
- Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээ (TRIMs)
- ТХЕХ-ийн 6-р зүйлийг хэрэглэх (дампингийн эсрэг татвар)
- ТХЕХ 94-ийн 7-р зүйлийг хэрэглэх (гаалийн зорилгоор барааны үнийг тодорхойлох)
- Тээвэрлэлтийн өмнөх шалгалт
- Гарал үүслийн дүрэм
- Импортын лиценз олгох журам
- Татаас, нөхөн олговор
- Онцгой хамгаалалтын арга хэмжээ

II. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр

III. Оюуны өмчийн эрхийн асуудлаарх хэлэлцээр (TRIPS)

IV. Маргаан хянан шийдвэрлэх журмын талаарх хэлэлцээр

V. Худалдааны бодлогыг дахин хянах механизм

VI. Олон талын гэрээ (цөөн тооны оролцогчидтой, өөрөөр хэлбэл ДХБ-ын бүх гишүүд заавал нэгдэн орох шаардлагагүй):

- Иргэний агаарын худалдааны хэлэлцээр
- Засгийн Газрын бэлтгэн нийлүүлэлтийн талаарх гэрээ

Дэлхийн Худалдааны Байгууллагын бүтэц

- Дээд байгууллага нь ДХБ-ын бүх гишүүн орнуудын төлөөлөгчөөс бүрдсэн Сайд нарын бага хурал. 2 жилд 1-ээс доошгүй удаа хуралддаг.
- Хуралдаануудын хооронд гишүүдийн төлөөлөгчдөөс бүрдэх Ерөнхий Зөвлөл (ЕЗ) шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хуралддаг.
- ЕЗ нь худалдааны бодлогыг хянах, маргааныг хянан шийдвэрлэхэд оролцдог.
 - ЕЗ нь дараах байгууллагуудын үйл ажиллагааг хянан зохицуулдаг. Үүнд:
 - Оюуны өмчийн худалдааны асуудал эрхэлсэн зөвлөл
 - Бараа худалдааны зөвлөл
 - Үйлчилгээний худалдааны зөвлөл
- Сайд нарын Бага хурлууд нь дараах асуудлаар Хороо байгуулдаг:
 - Худалдаа, хөгжил
 - Төлбөр, тооцооны тэнцлийг хангах зорилготой хязгаарлалтууд
 - Төсөв, санхүүгийн удирдлага
 - Худалдаа, хүрээлэн буй орчин
 - Бүсийн худалдааны хэлэлцээр
- Зөвлөл, хороодод гишүүнээр элсэх эрх нь бүх гишүүн орнуудад нээлттэй байна.
- Сайд нарын Бага хурал нь ДХБ-ын Ерөнхийлөгчийг томилдог.
- Сайд нарын Бага Хурлаас баталсан ДХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын албан тушаалууд, тэдгээрийн эрх үүргийг, ажиллах нөхцөлийг Ерөнхийлөгч томилно.
- 2005 оны эхэн үеийн байдлаар ДХБ-ын идэвхтэй гишүүдийн тоо 148 хүрсэн байна.
- Шинээр элсэн орох хүсэлтээ дараах орнууд өгөөд байна. Үүнд:
 - ОХУ
 - Саудын Араб
 - Украин
 - хуучин **ТУХН** орнуудын дийлэнх
- 60 орчим олон улсын байгууллагууд ДХБ-д ажиглагчийн статус эдэлдэг.
- ДХБ-д элсэх үйл явц удаан үргэлжилдэг нарийн цогц үйл ажиллагаа юм.
- Дэлхийн худалдааны 95%-ийг ДХБ-ын дүрэм, журам зохицуулдаг.
- Дэлхийн худалдааны хөгжлийн гол чиглэл нь либералчилал ба даяарчлал юм.
- Уругвай болон ТХЕХ 1986-1994-ийн хүрээн дэх хэлэлцээрүүдийн дүнд дэлхийн худалдааны барааны гаалийн татварыг багасгасан юм. Үүнд:
 - Үйлдвэрлэл хөгжсөн орнуудад 6.3%-3.9%
 - Эдийн засаг нь шилжилтийн үед байгаа улс 8.6-6.0%
 - Хөгжиж буй орнууд 15.3-12.3%

Хавсралт 2. Ажлын хэсгийн үйл ажиллагаа ба Сайд нарын бага хурлын тэмдэглэл

1996 оны 10-р сар - 4 дэх хуралдаан

- ХАА-д дэмжлэг үзүүлэх талаарх ОХУ-ын баримтлах бодлого
- Тарифын бус зохицуулалтын арга хэмжээ
- Бараанд тавих гаалийн хяналт

1997 оны 7-р сар - 6 дахь хуралдаан

- Худалдаан дахь техникийн шинжтэй саад тотгорууд (стандарт, зөвшөөрөл олгох, эрүүл ахуйн шаардлагууд)

1998 оны 7-р сар - 8 дахь хуралдаан

- ХАА-н асуудлууд
- Үйлдвэрийн бүтээгдэхүүнээс татаас авах асуудал, үүнд ХАА-н бүтээгдэхүүн хамаарна
- Худалдаан дахь техникийн шинжтэй саад тотгорууд

1998 оны 12-р сар - 9 дэх хуралдаан

- ХАА-н салбарт үзүүлэх Засгийн газрын дэмжлэг, экспортод үзүүлэх хөнгөлөлт

1999 оны 10-р сар, 2000 оны 5-р сар - 10, 11 дэх хуралдаан

- Гишүүн орнуудын олон талт зөвлөлдөөн

2002 оны хавар - 14, 15 дахь хуралдаан дараах асуудлуудыг хянасан:

- ОХУ, ДХБ-д элсэн орох талаар хийгдэж буй арга хэмжээний анхны тайлан
- 1995 оноос хойшхи бүхий л хэлэлцээрүүд
- ОХУ-ын худалдааны журам, тэдгээр нь ДХБ-тай нийцэж буй эсэх
- 1995 оноос Нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барьсан бүхий л судалгаа, шинжилгээний баримт бичгүүд, 1000 гаруй хуулиуд

2002 оны 12-р сар - 16 дахь хуралдаан

- Тайлангийн 2 дахь хувилбарыг хэлэлцэх эсэх асуудлаар

2003 оны 3-4-р сар - 17, 18, 19 дэх хуралдаанууд

- Тайлангийн 2 дахь хувилбарыг хэлэлцэх

2003 оны 7-р сар - 20 дахь хуралдаан

- Тайлангийн 3 дахь хувилбарыг хэлэлцэх
 - Мөнгөн тэмдэгтийн зохицуулалт
 - Утасны харилцаа холбоо
 - Бараа, үйлчилгээний зах зээл

2003 оны 9-р сар - Сайд нарын 5-р Бага хурал, Канкун, Мексик

- Завсрын үр дүнгийн талаар хэлэлцэх
- Олон талт худалдааны хэлэлцээрийн цаашдын үйл явцын талаар шийдвэр гаргах
- ДХБ-д элсэн орсны дараа ОХУ-ын өнөөгийн болон цаашдын ашиг сонирхлын асуудал
- ДХБ-д элсэн орсны дараах ОХУ-ын дэлхийд эзлэх байр суурь
- 30 гаруй орны төлөөлөгчидтэй ДХБ-д элсэн орохтой холбогдуулан хэлэлцээ хийх
 - Үүнтэй адил уулзалтуудыг 2003 онд Тайландын Бангкок хотноо болсон АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр хийсэн

2003 он 10-р сар - 21 дэх хуралдаан

- Тайлангийн шинэчлэгдсэн 9 хэсгийн талаар хэлэлцэх
- ОХУ-ын хууль тогтоомжид үзүүлэх нөлөөллийг дүгнэх
- Олон талт зөвлөлдөөн:
 - Утсан харилцаа холбоо, банкны үйлчилгээ
 - Тарифын квот
 - Үйлчилгээ, хөдөө аж ахуйн худалдааг үндэсний тааламжтай нөхцөлийн дэглэмээс чөлөөлөх
 - Бараа, үйлчилгээний зах зээл нээлттэй байх

2004 оны 2-р сар - 22 дахь хуралдаан:

- Дараах асуудлыг хэлэлцэж батлав:
 - Тайлангийн шинэчлэгдсэн 10 хэсэг
 - ОХУ өөрийн хууль тогтоомжоо ДХБ-ын дүрэм, журмуудтай нийцүүлэх оролдлого
- ОХУ-ын хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаарх олон талт зөвлөлдөөн:
 - Гаалийн Кодекс
 - ХАА болон тарифын квот
 - Бараа, үйлчилгээний зах зээл нээлттэй байх

2004 оны 3-р сарын 29-4-р сарын 2 - 23 дахь хуралдаан

- Тайлангийн шинэчлэгдсэн хэсгүүдийг хэлэлцэж батлах
- ХАА болон тарифын квотын талаарх зөвлөлдөөн

2004 оны 6-р сар - 24 дэх хуралдаан

- Тайлангийн шинэчлэгдсэн 13 хэсгийг хэлэлцэж батлах
- 25 дахь хуралдаанд тайлангийн 3 дахь хувилбарыг танилцуулахад хийх бэлтгэл

2004 оны 11-р сар - Олон талт зөвлөлдөөн, Женев хот, Швейцарь

- Худалдаан дахь техникийн шинжтэй саад тогорууд
- Эрүүл ахуй, ариун цэврийн арга хэмжээ
- 25 дахь хуралдааны бэлтгэл ажил

2004 оны 11-р сар - 25 дахь хуралдаан

- ОХУ ДХБ-д нэгдэх хүрээнд хийгдэж буй ажлын Тайлангийн 3 дахь хувилбарыг батлах
- ДХБ-д ОХУ элсэн орсноор хүлээх үүргийг дахин хянах, батлах
- ОХУ-ын төлөөлөгчдөд тавих нэмэлт асуултуудыг боловсруулах

2005 оны 2-р сар - 26 дахь хуралдаан

- ОХУ-ын өлөөлөгчдөд тавих асуултуудыг хэлэлцэх

2005 оны 4-р сар - 27 дахь хуралдаан, Женев хот, Швейцарь

- Хууль тогтоомжийг системчлэн хөгжүүлэх асуудлууд
- ОХУ-ын хууль тогтоомжийг ДХБ-ын шаардлагад нийцүүлэх ажил
- ОХУ-ын хүлээх үүргийн талаар Европын холбоо болон АНУ-тай 3 талт хэлэлцээр хийх
- Бараа, үйлчилгээний зах зээл дээрх нээлттэй байдлын талаар Канад, Япон,

Швейцарь, Мексик зэрэг улсуудтай 2 талт хэлэлцээр хийх

- Япон улстай баримт бичгийг байгуулах эхний шатуудыг эхлэх
- Турк улстай хийх бараа, үйлчилгээний талаарх Протоколыг батлах, гарын үсэг зурах

2005 он 6-р сар - 28 дахь хуралдаан, Женев хот, Швейцарь

- Бараа, үйлчилгээний зах зээл нээлттэй байх нөхцөлийн талаар 2 талт хэлэлцээр
- ХАА, эрүүл ахуйн арга хэмжээний талаарх олон талт зөвлөлдөөнүүд
- Ажлын хэсгийн бичсэн тайлангийн талаарх олон талт хэлэлцээр
- Эрүүл ахуйн арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын талаар ОХУ тавих илтгэл
 - Мал эмнэлгийн байцаагчдын өнөөгийн тогтолцоо
 - Эрсдэлээс сэргийлэх даатгалын систем

2005 оны 6-р сар 24 - Сайд нарын бага хурал

- Эдийн засаг, худалдааны сайд Оскарович Грефийн хэлэлцээ:
 - Зах зээлийн эдийн засагт шилжихэд ОХУ-д тулгараад буй бэрхшээл
 - 2006 оноос өмнө ОХУ ДХБ-д нэгдэн орох асуудал

2005 оны 10-р сар - 29 дэхь хуралдаан

Хавсралт 3. Сэдэвт орсон нэр томьёо, тодорхойлолт

1. Онцгой татвар

Онцгой татварыг ямар нэгэн хамгаалалтын тусгай арга хэмжээг нэвтрүүлэх үед хэрэглэдэг ба импортын татвар хураасан эсэхээс үл хамаарч ОХУ-ын Гаалийн албанаас нэмэгдүүлэн авдаг татвар юм.

Хамгаалалтын онцгой арга гэдэг нь ОХУ-ын Засгийн газрын шийдвэрээр ОХУ-ын гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх импортын хэмжээ нэмэгдэх явдлыг хязгаарлах арга хэмжээ бөгөөд импортын квот тогтоох, тусгай татвар ногдуулах (үүнд анхдагч онцгой татвар хамаарна) зэрэг аргаар хэрэгжүүлдэг байна.

Анхдагч онцгой татварыг судалгааны үр дүн илрэхээс өмнө авдаг ба гаалийн албаны шууд орлого болдог байна. Шалгалтын үр дүн, анхдагч онцгой татварын хэмжээ зэргийг холбооны төсөвт жагсаадаг буюу гаалийн төлбөрийн буцаан төлөгдөх байдлаар уг татварыг төлөгч этгээдэд олгодог байна. Анхдагч онцгой татварын хүчинтэй байх хугацаа нь 200 өдрөөс хэтэрч болохгүй.

2. Дампингийн эсрэг татвар

Энэ нь **дампингийн эсрэг арга хэмжээ** нэвтрүүлэх үед ногдуулдаг татвар ба импортын гаалийн татвар хураасан эсэхээс үл хамааран Гаалийн байгууллагаас хураадаг байна.

Дампингийн эсрэг арга хэмжээ гэдэг нь импортын **дампинг** буюу өөрийн гүйлгээгүй барааг бусад оронд хямд **нэвтрүүлэх** үйл ажиллагааны эсрэг арга хэмжээ юм. Үүнийг ОХУ-ын Засгийн газрын шийдвэрээр дампингийн эсрэг татварыг нэвтрүүлэх, үүнд **дампингийн эсрэг анхдагч татвар** хамаарна эсвэл экспортлогчийн зөвшөөрснөөр үнийн үүрэг хүлээлгэх зэрэг орно.

Дампингийн үйл ажиллагааны гол бүтээгдэхүүнүүдийг **Гаалийн алба** тусгай судалгаагаар илрүүлэх замаар тэдгээр барааны импортод **дампингийн эсрэг арга хэмжээг** авах боломжтой. Дампингийн бараанд дараах тохиолдолд дампингийн эсрэг арга хэмжээ авч болно:

- Оросын эдийн засгийн тодорхой салбарт материаллаг хор хохирол учруулж буй
- Оросын эдийн засгийн тодорхой салбарт материаллаг хор хохирол учруулж болзошгүй байвал
- Оросын эдийн засагт шинэ салбар нээгдэх үйл явцыг сааруулж байвал

Дампингийн импорт гэдэг нь адил барааны ердийн үнээс хямд үнэ бүхий ОХУ-ын гаалийн нутаг дэвсгэр дэх барааг хэлнэ.

Оросын эдийн засгийн салбарт **материаллаг хохирол** учруулах гэдэгт ОХУ-ын эдийн засгийн салбар дахь ойролцоо бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ багасах, тухайн бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрснээр дараах хүчин зүйлст сөргөөр нөлөөлөхийг ойлгоно. Үүнд:

- Эдгээр бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ашиг
- Хөрөнгө оруулалтын түвшин, хэмжээ
- Өргөн хэрэглээний барааны нөөц
- Ажил эрхлэлт
- Цалингийн хэмжээ, түвшин

Судалгаа хийгдэж дуусахаас өмнө **дампингийн импорт** мөн болох, түүнчлэн ОХУ-ын эдийн засагт хохирол учруулсан тухай мэдээлэл ирвэл ОХУ-ын Засгийн газар тухайн мэдээллийг үндэслэн **дампингийн эсрэг анхдагч татварыг** нэвтрүүлэх замаар **дампингийн эсрэг арга хэмжээг** авахаар шийдвэрлэнэ.

Дампингийн эсрэг анхдагч татвар ногдуулах шийдвэр нь судалгаа эхэлснээс хойш хуанлийн 60 хоногоос наана үйлчлэх боломжгүй юм. **Дампингийн эсрэг анхдагч татвар** нь ОХУ-ын гаалийн хууль тогтоомжид хамаарна. Хураагдсан **дампингийн эсрэг анхдагч татварыг** судалгааны эцсийн үр дүн гарахаас өмнө Холбооны төсөвт оруулдаггүй.

3. Тэнцвэржүүлэх татвар

Тэнцвэржүүлэх татвар нь нөхөн олговрын арга хэмжээг нэвтрүүлж буй үед хэрэглэдэг арга бөгөөд ОХУ-ын Гаалийн албанаас импортын гаалийн татвар төлсөн эсэхээс үл хамааран хураадаг байна.

Нөхөн олгох арга хэмжээ гэдэг нь гадаад улсын төрөөс буюу гадаад улс орнуудын нэгдлээс ОХУ-ын эдийн засгийн тодорхой салбарт үзүүлж буй дэмжлэгийн нөлөөг **саармагжуулах арга хэмжээ** юм. Үүнийг ОХУ-ын Засгийн газар тэнцвэржүүлэх татварыг (үүнд **тэнцвэржүүлэх анхдагч татвар хамаарна**) нэвтрүүлэх, түүнчлэн экспортлогч буюу гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээхээр зөвшөөрсөн үүргүүдийг батлах зэрэг аргаар хэрэгжүүлдэг байна.

Нөхөн олгох арга хэмжээг гадаад улсаас үзүүлэх **тодорхой дэмжлэгтэй** холбоотой бараанд, мөн дараах тохиолдлыг судалгааны дүнд илрүүлбэл хэрэглэж болно. Үүнд:

- Оросын эдийн засгийн тодорхой салбарт материаллаг хор хохирол учруулж буй
- Оросын эдийн засгийн тодорхой салбарт материаллаг хор хохирол учруулж болзошгүй байвал
- Оросын эдийн засагт шинэ салбар нээгдэх үйл явцыг сааруулж байвал

Гадаад орны **тусгай дэмжлэг** гэдэг нь хүртээмжийг хязгаарлагдмал байлгах дэмжлэг буюу барааны экспортыг эрчимжүүлэх болон импортыг **нөхөн орлуулах зорилгоор** үйлдвэрлэгч, экспортлогч, үйлдвэрлэгчдийн холбоо, экспортлогчдын холбоо, эдийн засгийн тодорхой салбар зэрэгт олгогддог дэмжлэг юм.

Судалгаа хийгдэж дуусахаас өмнө татаас бүхий импорт мөн болох, түүнчлэн ОХУ-ын эдийн засагт хохирол учруулсан тухай мэдээлэл ирвэл ОХУ-ын Засгийн газар тухайн мэдээллийг үндэслэн **тэнцвэржүүлэх анхдагч татварыг** 4 сарын хугацаатай нэвтрүүлэх замаар нөхөн олгох арга хэмжээг авахаар шийдвэрлэнэ.

Тэнцвэржүүлэх анхдагч татвар нь ОХУ-ын Гаалийн татварын хууль тогтоомжид хамаарах бөгөөд хураагдсан **тэнцвэржүүлэх анхдагч татварыг** нөхөн олговрын арга хэмжээг хэрэглэх талаарх судалгааны эцсийн үр дүн гарахаас өмнө Холбооны төсөвт оруулдаггүй.

Хавсралт 4. Мал эмнэлгийн болон эрүүл ахуйн шаардлагууд

ОХУ-ын гаднаас импортлох мах, махан бүтээгдэхүүнд тавигдах мал эмнэлгийн болон эрүүл ахуйн шаардлага

1. Экспортлогч улсын Төв нь Мал эмнэлгийн хяналтан дор ажилладаг, лиценз бүхий мах бэлтгэх комбинатуудад нядалсан эрүүл малын мах, махан бүтээгдэхүүн байх
2. Экспортлогч улсын Мал эмнэлгийн албаны нядалгааны өмнөх шинжилгээнд хамрагдсан байх. Уг малын махыг хүний идшинд хэрэглэж болох тухай дүгнэлт гарсан байх.
3. ОХУ руу экспортолж буй гулууз болон дотоод эрхтнүүдийг экспортлогч орны улсын Мал эмнэлгийн албаны нядалгааны дараах шинжилгээнд оруулсан байх. Уг малын махыг хүний идшинд хэрэглэж болох тухай дүгнэлт гарсан байх.
4. Гулууз (хагас, дөрөвний нэг)-ан дээр уг гулуузыг бэлтгэсэн мах бэлтгэх үйлдвэрийн (мах нядалгааны газар, хөргөгч) нэр, дугаарыг харуулсан Улсын мал эмнэлгийн Хяналтын албаны тамга дарагдсан байх ёстой. Махны савлагаанд мал эмнэлгийн шошгыг лац маягаар зүүсэн байх ёстой.
5. Дараах малын өвчингүй нутаг дэвсгэрийн фермд малласан эрүүл малын мах, махан бүтээгдэхүүнийг хүлээн авна:

А. Бүх амьтдад:

- Африк сармагчны халуун
 - Тус улсад сүүлийн 3 жил уг өвчин гараагүй бол
- Шүлхий өвчин
 - Тус улсад сүүлийн 12 сар уг өвчин гараагүй бол

Б. Үхэр:

- Үхрийн тархины эд сархиатах эмгэг болон хониний скрин
 - Уг өвчнүүд МАВ Олон улсын мал эмнэлгийн дүрэмд заасны дагуу тус улсад гараагүй бол
- Үхрийн тахал, үхрийн цээж, салстах өвчин
 - Уг өвчин тус улсад сүүлийн 12 сар гараагүй бол
- Сүрьеэ, бруцеллез, лейкоз
 - Фермийн нутаг дэвсгэр дээр уг өвчин сүүлийн 6 сар гараагүй бол
- Дуут хавдар
 - Фермийн нутаг дэвсгэр дээр сүүлийн 20 хоног уг өвчин гараагүй бол

В. Хонь, ямаа:

- Үхрийн тархины эд сархиатах эмгэг болон хониний скрин
 - Уг өвчнүүд МАВ Олон улсын мал эмнэлгийн дүрэмд заасны дагуу тус улсад гараагүй бол
- Хөх хэлтэх, тахал, үхрийн цээж
 - Тус улсад уг өвчин сүүлийн 9 сар гараагүй бол
- Аденоматис
 - Ферм дээр сүүлийн 3 жил уг өвчин гараагүй бол
- Хонь, ямааны цэцэг
 - Уг өвчин сүүлийн 12 сар фермийн нутаг дэвсгэр дээр гараагүй бол
- Сүрьеэ, бруцелёз
 - Уг өвчин сүүлийн 6 сар фермийн нутаг дэвсгэр дээр гараагүй бол
- Дуут хавдар
 - Сүүлийн 20 хоногт уг өвчин фермийн нутаг дэвсгэр дээр гараагүй бол
- Махны хэсэг бүр трихиносын сорилтонд орсон байх шаардлагатай

6. Хэвэгч мал, амьтны дотоод эрхтэн, хальсны гаралтай малын тэжээлээр тэжээгдээгүй үхэр, хонины махыг бэлтгэнэ.
 7. Инженерчлэл, генийн өөрчлөлт оруулаагүй зүйлээр хийсэн малын тэжээлээр тэжээгдээгүй мал махаар мах ба мах бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
 8. Дараах мах ба махан бүтээгдэхүүнийг ОХУ руу импортлохыг хориглоно. Үүнд:
 - А. Янз бүрийн бодист хордсон (нядалгааны дараах шинжилгээгээр илрэх) мах. Үүнд:

• Шүлхий	• Тахал	• Бактерийн халдвар	• Сүрьеэ
• Лейкоз хелминдез	• Цистоциркоз	• Трихноллез	
• Саркоз	• Онкоцеркоз	• Хнококк	
 - Б. Хадгалалтын явцад иссэн
 - В. Муудсан
 - Г. Хөлдүү мах 8 хэмээс дээш, хөргөсөн мах 4 хэмээс дээш, дотоод булчингийн халуунтай бол
 - Д. (Загас, эм тан, эмийн ургамал мэт) эвгүй үнэр, өнгө, амттай бол эсвэл дараах шинжтэй бол:

• Гэдэс дотортойгоо байгаа бол	• Ил шарх
• Механик нэмэлт хольц орсон бол	• Арьсны гэмтэл
 - Е. Муудахаас хамгаалах бодис хэрэглэсэн бол
 - Ё. Иж балнад болон бусад нян тээж байгаа бол
 - Ж. Ионы үйлчлэл, өнгө оруулагч, хэт ягаан туяанд байсан бол
 3. Мах бэлтгэх явцад нядалгаанаас өмнөх зохих хугацаанд дааврын бэлдмэл зэрэг эм бэлдмэлийг хэрэглээгүй бол
9. Махны микробиологийн, химийн хорт бодис, хэт ягаан туяаны радиац агуулах хэмжээ нь ОХУ-ын мал эмнэлгийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байх ёстой.
 10. Сав, баглаа, боодол нь хаях боломжтой, мөн эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх ёстой.
 11. Тээврийн хэрэгсэл нь экспортлогч орны тээврийн журамд заасан шаардлагыг хангасан байх ёстой.
 12. Энэ журамтай нийцсэн гэдгийг экспортлогч орны Мал эмнэлгийн албанаас олгосон гэрчилгээгээр баталгаажуулсан байх ёстой. Гэрчилгээг экспортлогч орны хэл болон Орос хэлээр бичсэн байх ёстой.
 13. Импортлогч ОХУ-ын ХАА, Хүнсний яамны дэргэдэх Мал эмнэлгийн албанаас зөвшөөрөл авсан тохиолдолд мах ба махан бүтээгдэхүүнийг ОХУ руу тээвэрлэж болно.
 14. ОХУ-ын ХАА, Хүнсний яамны дэргэдэх Мал эмнэлгийн алба нь мал эмнэлгийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх нядалгааны өмнөх шалгалт/шинжилгээг хийх, экспортлогч үйлдвэр дээр гулууз болоод гэдэс дотрын шинжилгээ хийх, түүнчлэн бүтээгдэхүүнийг ОХУ-д нийлүүлэхэд бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор үйлдвэрүүдэд шалгалт хийх эрхтэй байна.

Russia's Accession to The World Trade Organization

Fact-Finding Analysis on Mongolian-Russian Non-Tariff Barriers and Standards in Trade

Project No. G/21/04

*Prepared for
Deutsche Gesellschaft fuer Technische Zusammenarbeit (GTZ),
Export-oriented Industrial and Trade Policy Project, Mongolia*

*By:
ELC – Economic and Legal Consultancy LLC*

Ulaanbaatar, Mongolia

December 2005

TABLE OF CONTENTS

ACKNOWLEDGMENTS	2
DISCLAIMER	3
EXECUTIVE SUMMARY	4
1. Study Goals	5
2. Data Collection and Analysis	6
3. List of Researched Non-Tariff Barriers and Measures	6
INTRODUCTION	7
1. WTO and Russia	7
2. Mongolian-Russian trade	8
RUSSIA'S ACCESSION TO THE WTO	10
1. Advantages and Disadvantages	11
2. Benefits	11
3. Costs	11
INTERNATIONAL TARIFF REGULATION IN RELATION TO RUSSIAN POLICIES	12
1. Tariff Regulation of International Trade	12
2. Development of Russian Customs and Tariff Policies	13
3. Tariff Policies of Russia's Accession to the WTO	14
4. Non-Tariff Regulation of International Trade	14
5. International Legal Systems in the Coordinated Application of Non-Tariff Regulation in International Trade	15
6. Russia and the WTO: Agricultural Aspect	16
7. The Agreement on Application of Sanitary Measures	16
8. National System of Preferences of the Russian Federation	17
MONGOLIAN-RUSSIAN TRADE AND CHALLENGES OF NON-TARIFF BARRIERS	18
1. Mongolian-Russian Trade Today	18
2. Activities Performed Regarding Russia's Effort to Join the WTO	19
CHALLENGES FACED BY MONGOLIAN EXPORT COMPANIES	20
1. Quotas on Meat Exports	21
2. Territorial Limitation on Meat Exports	22
3. Veterinary and Sanitary Control	22
4. Requirements of Standards	23
CHALLENGES FACED BY MONGOLIAN IMPORTING COMPANIES	24
CHALLENGES FACED BY INDIVIDUAL TRADERS (ALTANBULAG and SELENGE AIMAGS)	25
CHALLENGES IN TRANSPORTATION AND TRADE	27
